

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

25  
ЖИЛ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2019 · 12 сар | Дугаар 14

## ГАРЧИГ

**2-4** Монгол Улсын банкнаас бусад санхүүгийн зах зээлийн түүхэн хөгжил

**4-5** Зохицуулалтын мэдээ

**6-7** Олон тулгуурт, хүртээмжтэй, ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлоох нь бодлого гаргагчид бидний нэн тэргүүний зорилт юм

**8-10** 2019 онд финтекийн салбарт

**10-13** Санхүүгийн байгууллагуудаас үүсэх системийн эрсдэлийг удирдах макро зохистой бодлого

**14** Ухаалаг шийдвэр гаргалт, ухаалаг хөрөнгө оруулалт

**15-17** Өргөн дуран

**18-19** Хэрэглэгч

**20-21** Зах зээлийн мэдээ

**22-23** Олон улсын зах зээлийн мэдээ

**24** 2020 онд болох үйл явдлууд

## Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.
- 976 51 261611
- [press@frc.mn](mailto:press@frc.mn)
- [www.frc.gov.mn](http://www.frc.gov.mn)
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC\_of\_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба



## Мөнгөжилгээ

Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, үе үеийн ажилтан, албан хаагчид, салбарын холбоод, хэрэглэгчид, иргэд Та бүхэндээ Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жил, арилжааны даатгалын салбар үүсч хөгжсөний 85 жилийн ойн баяр давхацсан онцгой жилийн баярын мэнд дэвшүүлэхийн ядамд айлчлан ирж буй 2020 ондоо ололт амжилтаар дүүрэн байхыг ерөөн шинэ жилийн мэнд дэвшүүлье!

1994 оны 9 дүгээр сард Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдаж, мөн оны 11 дүгээр сард Үнэт цаасны

хороо байгуулагдсанаар өнөөгийн санхүүгийн зохицуулагч байгууллага үүссэн түүхтэй. Түүнчлэн Даатгалын албыг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1934 оны 33 дугаар тогтоолоор “Улсын аюулаас хамгаалах газар” нэртэйгээр Сангийн яамны бүтцийн нэгж болгон байгуулах шийдвэр гарснаар даатгалын салбарын үндэс суурь тавигдсан ба үүнээс хойш өдгөө 85 жилийн нүүрийг үзжээ.

Энэхүү 85 жилийн хугацаанд манай улсын түүхэн дэх арилжааны даатгалын харилцааг зохицуулсан анхны хууль болох “Даатгалын тухай” хуулийг 1997 онд, мөн 2004 онд Даатгалын тухай хуулийг шинэчлэн, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг шинээр баталснаар зах зээлийн эдийн засгийн харилцаан дахь даатгалын байгууллагын үйл ажиллагааны хууль, эрхзүйн орчны зохицуулалт шийдэгдэж, Монгол Улсад даатгалын зах зээл өргөжин хөгжих шинэ үеийн эхлэлийг тавьсан билээ.

Түүнчлэн УИХ-аас 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хуулийг баталснаар 2006 онд Санхүүгийн зохицуулах хороо банкнаас бусад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хариуцан ажиллах болсон.

Сүүлийн жилүүдэд Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн болон хадгаламж зээлийн хоршооны салбарыг бодлого зохицуулалтаар хангахын сацуу шинэ технологи, бүтээгдэхүүнүүдийг цаг алдалгүй нутагшуулж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахыг зорин урагшилж байна. Өнгөрөгч он Санхүүгийн зохицуулах хорооны хувьд үйл ажиллагаа болон санхүүгийн зах зээлд өндөр өсөлт, шинэчлэл дүүрэн жил байлаа. Монгол Улсын даатгал, хөрөнгийн зах зээл, ББСБ, ХЗХ-ны голлох үзүүлэлтүүд 30 гаруй хувиар өсөж, зах зээлийн бодит сэргэлт бий болжээ.

Ирэх онд Санхүүгийн зохицуулах хороо салбарын оролцогчдыг улам бүр чадавхжуулах, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд хямд үнэтэй, өргөн сонголт бүхий санхүүжилтийн арга хэрэгслийг санал болгох богино хугацааны зорилгыг дэвшүүлээд байна.

Санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө сэтгэл, итгэл, оюунаа зориулан ажилладаг нийт албан хаагчид, бидэнд итгэл хүлээлгэн хамтран ажилладаг Мэргэжлийн холбоод, зохицуулалтын байгууллагууддаа, мөн иргэд, хөрөнгө оруулагч, даатгуулагч, хэрэглэгч та бүхэндээ талархал илэрхийлье. 2020 он Санхүүгийн зохицуулах хорооны хувьд эрхэм зорилго, алсын хараа, зорилго, зорилтдоо тууштай байж, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг өндөр түвшинд хамгаалж, зах зээлд гарч буй өсөлт, хөгжлийг тогтвортой үргэлжлүүлж, амжилтаа ахиулсан жил болно гэдэгт итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

## Санхүүгийн зохицуулах хорооны

### АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

### ҮНЭТ ЗҮЙЛС

**Цогц мөн чанар:** Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

**Хариуцлагатай байх:** Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

**Мэргэжлийн байх:** Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

**Бие даасан байх:** Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

**Манлайлал, санаачлагатай байх:** Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

**Багаар ажиллах:** Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

**Бидний үнэт зүйлс юм.**



## ГОЛЧ

# МОНГОЛ УЛСЫН БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

СУДАЛГАА, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Н.НАРАНТУЯА

Санхүүгийн зах зээл нь эдийн засгийн нэмүү өртөг бүтээгчдэд хөгжлийн ялгаатай үе шатуудад нь зориулан санхүүжилтийн хэрэгцээг хангах үүрэгтэй чухал салбар. Манай улсад санхүүгийн зах зээлийн дэд салбарууд харилцан адилгүй хугацаанд үүсч, өдгөө хөгжин дэвшсээр байна. Санхүүгийн зах зээлийн хөгжлийн замналыг түүчээлэхдээ хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцэж буй талаас нь үйл ажиллагаа, дэд бүтэц, зохицуулалт зэргийг хангалттай түвшинд хөгжсөн эсэхийг харуулахыг зорьлоо.

**Үнэт цаасны зах зээл:** Эдийн засгийн хөгжлийг илэрхийлэх үзүүлэлт нь хөрөнгийн зах зээлийн хөгжил байдаг. Манай улсад 1924 онд Монголын худалдаа, аж үйлдвэрийн банк байгуулагдсанаар санхүүгийн зах зээлийн суурь тавигдсан бол хөрөнгийн зах зээл нь 1991 оны өмч хувьчлалаар дамжин үүссэн байдаг нь дэлхий дахинд Нидерландын Амстердам хотод анхны хөрөнгийн бирж байгуулагдсанаас 200 жилийн дараах үйл явц юм. Ардчилсан хувьсгалын дараа ард иргэдийг хувийн өмчтэй болгох их өрнөлтийн нэг улсын өмчит компаниудыг хувийн өмчид шилжүүлж, Монгол улсын иргэн бүрт хувьцаа хуваарилах болсон. Үүний тулд 1991 оны нэгдүгээр сарын 18-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК үүсгэн байгуулагдаж, арилжаа явуулах брокеруудийг бэлтгэн 29 брокерын компанийг 18 аймаг, 3 хотод нээснээр цэнхэр тасалбараар ард иргэдэд хувьцаа эзэмшүүлэхэд бэлтгэв.

1992–1995 онуудад Монгол улсын засгийн газрын өмч хувьчлалын бодлогын хүрээнд нийт 475 улсын үйлдвэрийн газрыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн бүртгэж нийт 96.1 сая ширхэг хувьцааг МХБ–ээр дамжуулан 801 мянган иргэнд эзэмшүүлж, 8.3 тэрбум төгрөгийн гүйлгээг хийжээ.

Монголын хөрөнгийн бирж нь 1995 оны 8 дугаар сарын 28-ны өдөр үнэт цаасны бэлэн мөнгөний арилжааг эхлүүлж, 451 компанийн хувьцааг анх удаа арилжаанд оруулсан байдаг. Улмаар тухайн өдөр 16 компанийн



12.3 мянган ширхэг хувьцааг арилжаалж, 2.3 сая төгрөгийн гүйлгээ хийснээр хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэн.

Өмч хувьчлалын нөлөөгөөр үүссэн хөрөнгийн зах зээл олон улсын жишигт хүрэхээр 28 жилийн хугацааг туулахдаа хөгжлийн 5 үе шатыг дамжжээ. Энэ хугацаанд Үнэт цаасны тухай анхны хууль 1994 онд шинээр, 2002, 2013 онуудад тус тус шинэчлэгдэн батлагдсан.

1. 1991 – 1995 онуудад цэнхэр тасалбараар иргэдэд өмч хувьчилж, хууль, эрхзүйн орчин бүрэлдэж эхэлсэн үе.
2. 1996 – 2000 онуудад үнэт цаасны зах зээлийн хоёрдогч арилжаа явагдсан.
3. 2001 – 2005 онуудад иргэдийн хөрөнгийн зах зээлийн мэдлэг хомс байсны улмаас компанийн хувьцааг төвлөрүүлэх үйл явц эрчимжсэн.
4. 2006 – 2011 онуудад эдийн засгийн өсөлттэй уялдан хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч, компаниудын үнэлгээ өсөж эхлэв.
5. 2012 – одоог хүртэл Үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэгдэн, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль шинээр батлагдсантай холбоотой зах зээлд хөрөнгө оруулалтын менежмент, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаас итгэмжлэн удирдах, кастодиан банк, өөрийгөө зохицуулах байгууллага болон давхар бүртгэлийн эрхзүйн харилцаа үүссэнээр дэд бүтэц хөгжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэх болсон.

Хөрөнгийн зах зээлийн хөгжил нь хуулийг нь батлаад бүтээгдэхүүн шинээр гаргах төдийд шууд хөгждөггүй, харин олон нийтийн хөрөнгийн зах зээлийн оролцоогоор соёл

бүрэлдэж, удаан хугацааны турш цэцэглэдэг.

**Даатгалын салбар:** БНМАУ–ын Сайд нарын зөвлөлийн 1934 оны 11 дүгээр сарын 24–ны өдрийн 33 тоот тогтоолоор даатгалын албыг “Улсыг аюулаас хамгаалах газар” нэртэйгээр байгуулсан нь Монгол улсад даатгалын тогтолцоо үүсч хөгжих үндэс суурийг тавьж, 1990 онд даатгалын ууган компани болох “Монгол даатгал” ХХК болж хувьчлагдсан. 1994 онд Сангийн яамнаас даатгалын компаниудад зөвшөөрөл олгох журмыг, 1997 онд Даатгалын тухай хуулийг баталснаар тус салбар бүрэлдэн бий болох хууль, эрхзүйн орчин тогтсон юм. Тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2004 оны 4 дүгээр сарын 30–ны өдөр, үүнтэй холбоотойгоор Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг батлан гаргаж, дагаж мөрдүүлснээр арилжааны даатгалын зах зээлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн зах зээлд өөрийн гэсэн байр суурийг нэмэгдүүлж шинэ түвшинд үйл ажиллагаагаа эрхлэн явуулах таатай нөхцлийг бүрдүүлсэн юм.

Дэлхийн банкнаас аливаа аюул, осол, гамшгийн үед төрд ирэх санхүүгийн ачааллыг бууруулах, гамшиг, ослын үед ард иргэд, байгууллагуудад учирч болзошгүй санхүүгийн хүндрэлийг хөнгөвчлөхөд даатгалын салбарыг идэвхжүүлэхэд, “Малын индексжүүлсэн даатгал”, НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр, Люксембургийн Засгийн газар хамтран бичил даатгалын төсөл, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк “Даатгалын зохицуулалтыг боловсронгуй болгох, чадавхижуулах төсөл” зэрэг олон төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлээд байна.

Даатгалын хууль, эрх зүйн орчин ч улам сайжирч 2011 оны 10 дугаар сарын 06–ны өдөр Жолоочийн хариуцлагын даатгалын тухай хууль, 2014 оны 6 дугаар сарын 13–ны өдөр Малын даатгалын тухай хуулийг тус тус шинээр баталж мөрдүүлснээр даатгалын зах зээлийн цар хүрээ, түүний улс орны нийхэм<sup>1</sup> эдийн засагт оруулах хувь нэмэр дээшилж байна.

1990 онд ердийн даатгал, 2008 онд урт хугацааны даатгал, 2015 онд төрийн өмчит, 2018 онд хувийн анхны давхар даатгалын компани байгуулагдаж, мөн зуучлагч, хохирол үнэлэгч, төлөөлөгч зэрэг дэд бүтцийн, андеррайтер, актуарч гэсэн үнэлгээний бүхий л хэсгүүд нь бүрдээд байна. Гэвч уг салбарын

чадавхийг зохицуулалт, эрсдэлийг үнэлэх, олон нийтийг эрсдэлээ даатгуулдаг болгох, тэдгээрийн итгэлийг хадгалах гээд олон талд нь бэхжүүлэх сорилтыг даван туулах даалгавар уг салбарын түүхийг бүтээгчдэд үлдээд байна.

**Хадгаламж, зээлийн хоршоо:** “Эдийн засагч эмэгтэйчүүдийн клуб”–ээс Монголын Эмэгтэйчүүдийн Төрийн бус байгууллагуудын анхдугаар чуулган, Зүүн Азийн орнуудын III чуулганыг эх орондоо зохион байгуулснаар банкуудын зээл олгодоггүй үлдсэн орон зайд санхүүгийн үйлчилгээ хүргэдэг хоршооллын байгууллага байж болохыг нийтээрээ санаачилсан. Ингэснээр 1996 онд анхны хадгаламж, зээлийн хоршоо Хоршооны тухай хуулин дээр тусгай зөвшөөрөлгүйгээр байгуулагдсан юм. Ийнхүү хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо олшрон 900–д хүрсэн ч бичил санхүүгийн үйлчилгээг хүргэх олон улсын стандартад нийцсэн нь цөөн байсны улмаас 2005–2007 онуудад уг хоршоод өндөр хүүтэй хадгаламж татан зээл олгосноос зээлийн эргэн төлөлтөд эрсдэл учран олноороо дамлуурах болсон.

Ингээд 2006 оноос хадгаламж, зээлийн хоршоодыг санхүүгийн зохицуулалтад оруулж тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлдэг болгосноор өдгөө зөвхөн гишүүддээ санхүүгийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Хадгаламж, зээлийн хоршоод нь санхүүгийн үйлчилгээ хүрч чаддаггүй хөдөө, орон нутагт илүү тархан байршжээ.

**Банк бус санхүүгийн байгууллага:** Монгол банкнаас санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхээр 2002 оны 12 дугаар сарын 12–ны өдөр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг батлуулж банк бус санхүүгийн байгууллага мэндэлсэн. Батлагдсан хуулийн дагуу банк бус санхүүгийн байгууллага нь зээл, факторинг, итгэлцлийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа, валют арилжаа, цахим төлбөр тооцооны нийт 10 төрлийн санхүүгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд жамаараа явсан уг салбар 2013 оноос эхлэн эрчээ авч 539–д хүрлээ.

**Бараа таваарын зах зээл:** 2011 оны 6 дугаар сарын 02–ны өдөр Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль батлагдаж, 2013 оны 5 дугаар сард бирж байгуулагдан Монголын анхны таваарын зах зээл үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Ингэснээр ченжүүдийн малын гаралтай бараа, түүхий эд малчдаас шууд авах ажиллагааг зогсоон

биржээр дамжуулан арилжих болсон. Уг зах зээлийн өмнө арилжааны үнийг эрэлт, нийлүүлэлтэд үндэслэн тогтоодог болох, арилжаалагдах бараа, бүтээгдэхүүний чанарын үнэлгээг стандартад хүргэх, нэмүү өртгийг нэмэгдүүлэх, жишиг агуулах байгуулах, тээвэрлэлтийн асуудлыг шийдвэрлэх ажиллагаанууд хийгдсээр байна.

**Зохицуулалтын орчин:** 1994 онд байгуулагдсан Үнэт цаасны хороо 2006 онд Санхүүгийн зохицуулах хороо болж байгуулагдан Монголбанкнаас хадгаламж, зээлийн хоршоо болон Банк бус санхүүгийн байгууллага, Мэргэжлийн хяналтын газраас даатгалын салбарын хяналт, зохицуулалт шилжин ирж Монгол улсад банкнаас бусад санхүүгийн зохицуулалтын байгууллага үүссэн түүхтэй. Уг байгууллагын зохицуулалтад ХАА–н бараа таваарын зах зээл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зэрэг санхүүгийн үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрүүд нэмэгдсээр байна. Санхүүгийн зах зээлийн харилцаанд оролцогч талуудын нийтлэг эрх ашгийг хамгаалахад оршин тогтнодог тус байгууллага нь 25 жилийн хугацаанд зах зээлийн оролцогчдын бүх талуудын эрх ашгийг хамгаалахыг зорин ажилласан.

**Технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ:** Олон улсад хэрэглэгчдийн амьдралын тав тухыг сайжруулахаар санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ ихээр дэлгэрч, санхүүгийн зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээг ч робот гүйцэтгэдэг боллоо. Энэхүү хөгжлийг даган манай улсын санхүүгийн байгууллагууд дижитал санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж эхэллээ. Тухайлбал цахим талбарт болон гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг банк бус санхүүгийн байгууллагууд нэвтрүүлээд байгаа бол брокерийн компаниуд цахимаар үнэт цаасны арилжааны захиалга өгөх үйлчилгээг санал болгодог болоод байна.




1 Нийхэм – Нийтээр Хэм–тэй амьдрах Нийгэм – Нийтээр Гэм–тэй амьдрах

Түүнчлэн дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө болон эх дэлхийгээ зүй бусаар ашиглаж буйтай холбоотой ногоон санхүүжилтийн зарчмыг эрхэмлэх, түүний талаар судалж санхүүгийн байгууллагууд, төдийгүй олон нийтэд хүргэх шаарлага тулгараад байна.

Эх дэлхийгээ хадгалж үлдэхийн тулд хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хүслийг хангах гэсэн онолыг эргэн санаж хувь хүн бүр худалдан авалтаа ухаалаг болгох нь зүйтэй. Тухайлбал, худалдан авах гэж буй зүйлээ байгаль орчин болон эрүүл мэндэд тань ээлтэй эсэхийг нягталж байгаарай.

Санхүүжилтийн хэрэгцээ, шаардлага: Санхүүжилтийн эрэлт талаас нь харахад

**Small Business Lifecycle**



манай улсад үйл ажиллагаа явуулдаг бизнесүүдийн ихэнх нь бичил, жижиг, дунд гэсэн ангилалд багтдаг бол

санхүүгийн зах зээл маань богино хугацаат санхүүжилт буюу өндөр хүүтэй бичил болон арилжааны банкны зээл, хөгжлийн

төлөвшсөн үе шатандаа явж байгаа компаниудыг хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд хувьцаагаа худалдах санхүүжилтийн нийлүүлэлт л байна. Харин хөгжлийн эхэн болон өсөлтийн үе шатандаа явж буй компаниудын санхүүжилтийн хэрэгцээг нийлүүлэх, тэдгээрийн өндөр эрсдэлийг авахад бэлэн гарааны бизнесийн хөрөнгө оруулалт дутагдалтай байна. Үүнийг Европын орнуудад эрсдэл хүлээн авахад бэлэн хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх, Япон улсад Хөрөнгийн бирж нь жижиг бизнес эрхлэгчдэд зориулсан хувьцаа гаргах бага шалгууртай самбарыг нээснээрээ шийдсэн байдаг.

**ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ**

**СЭХ КОМПАНИЙН БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЖАЙКА-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА**

Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран Санхүүгийн зохицуулах хороо “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хоёрдугаар үе шатыг 2019 оны гуравдугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн. Санхүүгийн зохицуулах хороо тус төслийн зөвлөхтэй компанийн бондын зах зээлийг хөгжүүлэх, биржийн бус зах зээлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ярилцлаа.

**ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАГЧДЫН ХОЛБОО “ДИЖИТАЛ ЭРИН ДЭХ ХЯНАЛТ” СЭДВЭЭР ЧУУЛЖ БАЙНА**

Даатгалын зохицуулагчдын олон улсын холбоо (International Association of Insurance Supervisors)-ны 26 дахь чуулга уулзалтыг “Дижитал эрин дэх хяналт” сэдвийн дор Арабын Эмират улсын Абу Даби хотноо 2019 оны 11 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд болж өндөрлөлөө. Сүүлийн жилүүдэд технологийн дэвшил нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой суваг болж байгаа бөгөөд зах зээлийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж даатгалын зах зээлийн хөгжлийн өөр нэгэн үе шатыг тодорхойлж эхэллээ.

Холбооны 2019 оны ээлжит хурал нь Удирдах зөвлөлийн дугуй ширээний уулзалт болон нэгдсэн хуралдаан гэсэн хүрээнд явагдаж, даатгуулагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бизнес загвар болон даатгалын бүтээгдэхүүнийг түгээх сувгийг шинэчлэх, мөн өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт хийж, шинэ зорилтыг тодорхойлох зэрэг бодлогын сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлэв.

Монгол Улс 2002 онд Санхүүгийн зохицуулах хороогоор төлөөлүүлэн тус холбооны жинхэнэ гишүүнээр элсэж Холбооны нэгдсэн зохицуулалт, зөвлөмжийг удирдлага болгон авахын зэрэгцээ дэлхийн 140 орчим орны 200 гаруй зохицуулагч байгууллагатай даатгалын зах зээлийн хөгжил, хяналт, зохицуулалтын сорилт, туршлага, шинэ санаачилга, ололт амжилтаа хуваалцан хамтран ажилладаг.



**IAIS 2019**  
11 - 15 November  
Abu Dhabi, UAE

**“НОГООН САНХҮҮ” ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ БОЛЛОО**

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI) Мароккын төв банк (BAM) хамтран “Ногоон санхүү олон улсын бага хурал, “Хүртээмжтэй ногоон санхүү сургалт”-ыг аравдугаар сарын 28-30-ны өдрүүдэд Мароккын Вант Улсын нийслэл Рабат хотод зохион байгуулав.

Энэхүү олон улсын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллүүд оролцож хүртээмжтэй ногоон санхүүгийн бодлогын талаарх ойлголт, шинэ мэдээллийг олж авах, үндэсний хэмжээнд хамаарах бодлого боловсруулах, тэдгээрийг одоогийн хэрэгжүүлж буй санхүүгийн стратегитай уялдуулах гэх мэт ур чадвар, мэдлэг эзэмшиж, олон орны төлөөлөгчтэй хамтран ажиллаж, харилцан туршлагаа солилцсон байна.

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС “УИД” ХК-ИЙН ЖИЖИГ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЗОРИЛГООР ХИЙГДЭЖ БҮЙ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

Санхүүгийн зохицуулах хороо нь “УИД” ХК-ийн 45000 орчим жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тус



компанийн эрх бүхий албан тушаалтнуудын “УИД” ХК-ийн барилгыг гаднах талбайн хамт бүхэлд нь “Номин реалтор” ХХК-д түрээсэлсэн үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээнүүдийг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцуулж, компанид учруулсан 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулах, мөн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлээгүйн улмаас 2017 оны 4 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд компанид учруулсан 428.6 сая төгрөгийн хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнуудаар гаргуулахаар 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Санхүүгийн зохицуулах хорооны дарга нэхэмжлэл гаргаад байна.

### МОНГОЛ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ КОД “МОНВАЛ”-ЫГ

#### БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДЛАА

Монгол Улсын Засгийн газар болон Австрали Улсын Засгийн газрын хоорондын хоёр талт хамтын ажиллагааны буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлж буй “Австрали, Монголын Эрдэс баялгийн салбар дахь хамтын ажиллагааны хөтөлбөр”-тэй хамтран Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний код “МонВал”-ыг боловсруулах чиг үүрэг бүхий холбогдох байгууллагууд болон Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын төлөөллийг хамарсан ажлын хэсэг байгуулагдаад байна.

Ажлын хэсгийн анхдугаар хуралдаан 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр болж, ажлын хэсгийн гишүүд санал солилцон ажилласны зэрэгцээ кодыг боловсруулах чиглэлээр хийгдэж байсан ажлууд болон олон улсад ашигт малтмалын үнэлгээг хэрхэн хийдэг талаар хөтөлбөрийн уул уурхайн ахлах зөвлөх Н.Алгаа, хөтөлбөрийн зөвлөх, Олон улсын ашигт малтмалын үнэлгээний хорооны дарга Стивен Гемелл нар танилцууллаа.

Энэхүү кодыг нэвтрүүлснээр ашигт малтмалын хөрөнгийг арилжаалах явцад хуурамч үнэлгээ хийгдэхээс урьдчилан сэргийлэх, уул уурхайн салбарт олон нийтийн итгэх итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах юм. Мөн уул уурхайн компаниуд хөрөнгийн зах зээл дээр гарахад тухайн ашигт малтмалын нөөцийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу тайлагнадаг болох зэрэг чухал ач холбогдолтой.



### ХОРООНЫ 2019 ОНЫ XVI ХУРАЛДААН БОЛОВ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны XVI хуралдаан болж нийт 31 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар “Нийслэлийн өмчит Улаанбаатар” ХХК, “Эрдэнэс ассет менежмент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Хөвсгөл алтан дуулга” болон “Лэндмн ББСБ” ХК-иудын хаалттай хүрээнд гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэв.

Мөн “Мандал даатгал” ХК-ийн хувьцаа хуваах асуудлыг шийдвэрлэж, “Очун капитал” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, нэр бүхий 3 компанийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлж, нэг компанийн үнэт цаасыг бүртгэлээс хаслаа.

Түүнчлэн нэр бүхий үнэт цаасны компани, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, ББСБ-уудын үл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгах, зөвшөөрөл нэмж олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

### ХОРОО ДЭЛХИЙН БАНКТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Дэлхийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Андрей Михневийг хүлээн авч уулзан, Хороотой хамтран хэрэгжүүлж буй “Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн явц болон цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцаж, санал солилцов.



Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо сайжруулах хүрээнд ФАТФ-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр техникийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр боллоо.

### МОНГОЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧДИЙН ХОЛБООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАНА

Санхүүгийн зохицуулах хороо Монголын хохирол үнэлэгчдийн холбоотой 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Сургалт зохион байгуулах гэрээ”-г дахин 1 жилээр сунгаж хамтран ажиллахаар боллоо.

Гэрээний хүрээнд Хороо, Монголын хөрөнгө, хохирол үнэлэгчдийн холбоотой /нэр өөрчлөгдсөн/ хамтран 2019 оны 11 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд даатгалын хохирол үнэлэгчийн эрх олгох сургалтыг явуулж, нийт оролцогчдоос шалгалтыг авлаа. Шалгалтын талаарх мэдээллийг [www.frc.mn](http://www.frc.mn) цахим хаяганд байршуулсан болно.

### ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН “ДЕЛОИТТ-ОНЧ” АУДИТЫН КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗАВ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан “Делоитт-Онч” аудитын компанийн Хонг Конг дахь салбарын захирал Анир Бхаттачаря, Юичиро Мицүтоми, “Делоитт Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Норжинбат, ахлах зөвлөх М.Билгүүн нарыг хүлээн авч уулзав.

Уулзалтын үеэр Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах талаар, ялангуяа СЗХ-ны зохицуулалтад шинээр нэмэгдэж орсон санхүүгийн бус мэргэжлийн бизнесийн оролцогчдын эрсдэлийг үнэлэх, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр санал солилцож, хамтын ажиллагааны боломжуудын талаар ярилцлаа.



## БАЙР СУУРЬ



## ОЛОН ТУЛГУУРТ, ХҮРТЭЭМЖТЭЙ, УХААЛАГ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ЦОГЦЛООХ НЬ БОДЛОГО ГАРГАГЧИД БИДНИЙ НЭН ТЭРГҮҮНИЙ ЗОРИЛТ ЮМ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН:

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагт шилжээд удаагүй байсан манай улсын эдийн засагт томоохон өөрчлөлтүүд тохион өмч хувьчлал эхэлснээр хөрөнгийн зах зээлийн үндэс суурь тавигдсан байдаг. Улмаар 1994 оны 9 дүгээр сард анх “Үнэт цаасны тухай хууль” батлагдаж, тус оны 11 дүгээр сард “Үнэт цаасны хороо” байгуулагдсанаар Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага үүсгэн байгуулагдаж байсан нь өнөөдрөөс 25 жилийн өмнөх үйл явдал юм.

2006 онд даатгалын салбар, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын зохицуулалт, хяналтын үүргийг хүлээн авч “Санхүүгийн зохицуулах хороо” байгуулагдаж байсан түүхтэй. Өнөөдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороо нь хөрөнгө, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг банкнаас бусад санхүүгийн зах зээлийн нийт 3000 орчим мэргэжлийн оролцогчдыг хянаж, зохицуулан ажиллаж байна.

Мөн энэ онд Монгол Улсад даатгалын салбар үүсэн хөгжсөний 85 жилийн ой давхар тохиож байна. Анх 1934 онд БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн тогтоолоор “Улсыг аюулаас хамгаалах газар” байгуулагдаж байсан нь өнөөгийн даатгалын зах зээлийн үндэс суурь болсон юм.

Санхүүгийн зах зээл нь нөөцийг үр ашигтайгаар хуваарилах замаар эдийн засгийн өсөлтийг дэмждэг чухал салбар бөгөөд санхүүгийн зах зээлийн хөгжил нь тухайн улсын хөгжилд чухал нөлөөтэй болох нь олон улсын туршлага болон

эмпирик судалгааны үр дүнгээс харагддаг. Мөн бидний өдөр тутмын амьдралын нэг чухал хэсэг нь санхүүгийн харилцаа байдаг. Тэр ч утгаараа Монгол Улсын санхүүгийн зах зээл олон улсын жишгийн дагуу үүсч хөгжих нөхцөл бүрдсэн энэ түүхэн ой нь дан ганц санхүүгийн салбарын ажилтан, албан хаагчид бус иргэд, хэрэглэгчид бид бүхний баяр юм.

**Сүүлийн жилүүдэд банкнаас бусад санхүүгийн зах зээл тэр дундаа хөрөнгийн зах зээлд өндөр өсөлт тохиож байгаа нь статистик мэдээллээс харагддаг. Өнөөдөр манай улсын санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин ямар шатандаа явна гэж та харж байна вэ?**

Манай улсын санхүүгийн зах зээл нь банкны салбар давамгайлсан бүтэцтэй бөгөөд арилжааны банкуудын нийт зах зээлд эзлэх хувь өндөр. Харин эсрэгээрээ хөрөнгийн болон даатгалын зах зээлийн санхүүгийн салбарт эзлэх хувь хэмжээ өндөр хөгжсөн орнуудтай харьцуулахад бага байгаа юм. Гэхдээ манай улсын санхүү, хөрөнгийн зах зээл дэлхийн улс орнуудтай харьцуулахад ялгаатай цаг хугацаанд үүсэн, хөгжлийн ялгаатай үе шатыг туулж ирсэн гэдгийг санах нь зүйтэй юм. Тухайлбал дэлхийн анхны хөрөнгийн бирж 17-р зуунд үүсгэн байгуулагдаж байсан бол бид хувьцаагаа хөрөнгийн зах зээл дээр арилжаалж эхлээд 25 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Өөрөөр хэлбэл бид хөгжлийн 200, 300 жилийг үзсэн улс орнуудтай өөрсдийн зах зээлийг шууд харьцуулан дүгнэх нь өрөөсгөл юм.

Гэхдээ сүүлийн жилүүдэд банкнаас бусад санхүүгийн зах зээлд сэргэлт ажиглагдаж эхлээд байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, анхдагч зах зээл дээр хувьцаагаа санал болгож буй компаниудын тоо зэрэг үзүүлэлтүүд түүхэн түвшнээ давсан дүнтэй байгаа юм. Иргэд, хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгийн зах

зээлийн арилжаанд оролцох, өөрийн мөнгө хөрөнгийг дан ганц хадгаламжийн дансанд хуримтлуулах бус хөрөнгө оруулалт хийх байдлаар нэмэгдүүлэх сонирхол нэмэгдэж байгаа бол бизнес эрхлэгч аж ахуй нэгжүүд маань ч мөн адил хөрөнгийн зах зээлээс хувьцаа, бонд хэлбэрээр санхүүжилт босгох хандлага нэмэгдэж байна. Мөн даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын зах зээл сүүлийн жилүүдэд тогтмол 30-аас дээш хувийн өсөлтийг үзүүлж байна.

Түүнчлэн манай улсын санхүүгийн зах зээлд технологийн дэвшил нэвтрэн финтек гэж бидний нэршиж дадсан технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд хурдтай нэвтрэх эхлээд байгаа нь манай улсын санхүүгийн зах зээл дэлхийн чиг хандлагаас хоцроогүй байгааг илтгэж байгаа болов уу. Сүүлийн жилүүдэд хөрөнгө, даатгал, зээлийн зах зээлүүдэд технологийн дэвшил хурдтай нэвтрэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд санхүүгийн хэрэгцээгээ амар хялбар, түргэн шуурхай байдлаар шийдэх боломжийг олгож байна. Мөн технологийн дэвшлийн манай улсын санхүүгийн зах зээлд үзүүлж буй нэг томоохон нөлөө нь том, жижиг гэлтгүй бүхий л байгууллагуудад зах зээлд тэргүүлэх, банк давамгайлсан бүтэцтэй манай улсын санхүүгийн зах зээлийг тэнцвэржүүлэх боломжийг олгож байгаа явдал юм. Уул уурхай, эрдэс баялгийн бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай жижиг нээлттэй эдийн засагтай манай улсын хувьд санхүүгийн зах зээлээ олон тулгуурт болгон хөгжүүлэх нь системийн эрсдэлийг бууруулах, санхүү, эдийн засгийн шокоос хамгаалахад чухал юм.

Дүгнээд хэлвэл бид зах зээлийн хөгжлөө дан ганц хэмжээгээр дүгнэх бус өсөлт, сэргэлт, хүртээмж болон салбарт гарч буй технологийн дэвшил, инноваци, хамгийн чухал нь иргэд,

хөрөнгө оруулагчдын сонирхол, итгэлийг харгалзан үзэх нь чухал билээ.

### **Цаашид манай улсын санхүүгийн зах зээлийн ирээдүйн төлөв ямар байна гэж та харж байна вэ?**

Дан ганц санхүүгийн зах зээл гэлтгүй сүүлийн жилүүдэд бидний ирээдүйн амьдралыг тодорхойлох хамгийн чухал хүчин зүйл нь технологийн дэвшил болж байна. Хэдхэн жилийн өмнө л бид гар утас, интернет гэсэн ойлголттой анх танилцаж байсан бол өдгөө тэдгээр зүйлсгүйгээр мөн шинэ тутам гарч буй технологийн дэвшилгүйгээр бидний өдөр тутмын амьдралыг төсөөлөхөд бэрх болж байна. Хамгийн энгийн жишээ нь бид цаасан мөнгө эзэмшилгүйгээр цахим хэтэвч ашиглан орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр төлбөр тооцоогоо хийх боломжтой болсон байна.

Өмнө дурдсанчлан манай улсын санхүүгийн зах зээлд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хурдацтай нэвтэрч байна. Тухайлбал 2019 оны 3 дугаар улирлын байдлаар гэхэд манай улсын банк бус санхүүгийн байгууллагын зээлдэгчдийн 46.1 хувь нь гар утсаараа зээлийн үйлчилгээг авч, эдийн засгийн идэвхтэй хүн амын 76.0 хувь нь цахим мөнгө, цахим хэтэвч эзэмшиж байна. Мөн бид даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг цахим хуудас эсхүл гар утасны аппликейшн ашиглан авах боломжтой болсон бол хувьцааны арилжааг блокчэйн технологид суурилсан платформоор гүйцэтгэх санал, санаачлагыг финтек компаниуд гаргаж эхлээд байна.

Технологийн уг хурдацтай өөрчлөлт цаашид ч зах зээлд илүү нэвтрэн санхүүгийн зах зээл бүхэлдээ цахимжих болов уу гэж таамаглаж байна. Мөн хувь иргэн бүр өөрийн хүсэл, онцлогт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг орон зай, цаг хугацааны ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хүртдэг болох

өдөр тун удахгүй ирнэ гэдэгт найдаж, бас түүний төлөө бодлогоо чиглүүлэн ажиллахыг хичээж байна. Том, бага гэлтгүй бүхий л байгууллагуудад тэр ч бүү хэл өндөр хөгжсөн, хөгжиж буй бүхий л улсуудад гарааны тэгш боломжийг олгож буй технологийн дэвшлийг зах зээлдээ нэвтрүүлэн цахим, хүртээмжтэй, ухаалаг санхүүгийн зах зээлийг бүрдүүлэх боломж манай улсад байна гэж бид харж байгаа. Тийм ч учраас технологийн дэвшлийг дэмжиж ажиллахаа бид мэдэгдсээр ирсэн.

### **Санхүүгийн зохицуулах хороо ирэх онд ямар зорилтыг тавин ажиллах вэ?**

Олон тулгуурт, хүртээмжтэй, ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлоох нь санхүүгийн салбарын бодлого гаргагчид бидний хамгийн чухал, нэн тэргүүний зорилт юм. Тэр ч утгаараа бид бүхэн уг зорилгодоо тулгуурлан ирэх оныхоо зорилтыг чиглүүлж байна.

Санхүүгийн салбар иргэд, оролцогчдын итгэл, үйл хөдлөл дээр суурилан ажилладаг маш эмзэг салбар. Өөрөөр хэлбэл сул зохицуулалт, хяналт шалгалт нь зах зээлд итгэх итгэлийг бууруулах, идэвхтэй сэргэж буй уг зах зээлд хөөсрөл үүсгэх зэрэг олон сөрөг талтай бол хэт чанга зохицуулалт нь салбарын хөгжил, бүтээмжийг боомилох аюултай байдаг. Энэ ч утгаараа технологийн дэвшилд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний оновчтой зохицуулалтын орчин олон улс орны бодлого гаргагчдын гол анхаарах сэдэв нь болж байна. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд ч мөн адил технологийн дэвшилд суурилсан санхүүгийн зах зээлд оновчтой зохицуулалтын орчныг бүрдүүлэх, өөрсдийн үйл ажиллагаандаа технологийн шийдлийг нэвтрүүлэн ухаалаг зохицуулалтын орчныг бүрдүүлэх гэсэн томоохон ажил хүлээгдэж байна.


Мөн техник, технологийн өндөр өсөлтийг даган сүүлийн жилүүдэд хүн төрөлхтний

хамгийн их анхаарлыг татаж буй сэдэв бол тогтвортой хөгжил, тэр дундаа байгаль орчны асуудлууд юм. Бид ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлоохоор нэгэн зорилгын дор ажиллаж буй хэдий ч ухамсартай үйл ажиллагаа, тогтвортой хөгжлийг орхиуулж болохгүй. Энэ ч утгаараа бид санхүүгийн зах зээлд тогтвортой санхүүжилт, ногоон санхүүжилтийг нэвтрүүлэн ажиллана.

Ирэх онд манай улсын санхүүгийн зах зээлийг хүлээж буй хамгийн чухал сорилт бас бидний өмнөө тавьсан зорилт нь саарал жагсаалтаас гарах юм. Саарал жагсаалтаас нэн даруй хохирол багатайгаар гарахын тулд бид эрчимтэйгээр ажиллаж байгаа ба ирэх оны томоохон төлөвлөгөө нь тус ажил юм. Түүнчлэн Улсын Их Хурал, Засгийн газар, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс батлагдсан бодлогын баримт бичгүүд болон Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зэрэг нэлээн завгүй, хариуцлагатай жил биднийг хүлээж байна.

### **Ярилцсанд маш их баярлалаа. Танд болон танай байгууллагын хамт олонд ирж буй шинэ оны мэндийг хүргэхийн ялдамд Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жилийн ойн мэндийг хүргэе.**

Баярлалаа. Санхүүгийн зохицуулах хорооны үе үеийн нийт албан хаагчид тэдний гэр бүл болон санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагууд, тус зах зээлийн хөгжлийн төлөө хичээнгүйлэн ажиллаж буй салбарын мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоод болон хэрэглэгч, хөрөнгө оруулагчид, иргэд та бүхэндээ Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жил, даатгалын салбар үүсч хөгжсөний 85 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Ирж буй 2020 ондоо та бүхэн минь амжилт бүтээлээр дүүрэн байх болтугай.



## ФИНТЕК БА РЕГТЕК

### 2019 ОНД ФИНТЕКИЙН САЛБАРТ

Финтекийн<sup>1</sup> салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэвтрэлтийн түвшин: Сэтгүүлийн энэ дугаараар Ernst & Young олон улсын байгууллагаас гаргадаг “Global FinTech Adoption Index” буюу финтекийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэвтрэлтийн түвшний тайлангийн 2019 оны 3 дахь удаагийн дугаараас орууллаа.


Нэвтрэлтийн түвшинг тооцохдоо иргэдээс болон аж ахуйн нэгж, тэр дундаа жижиг, дунд үйлдвэрүүдээс цахим асуулгын аргаар судалгааг түүвэрлэн авсан байна.

Финтекийн нэвтрэлтийн түвшин – Иргэдэд: Судалгаанд нийт 27 орны “digitally active” буюу дижитал орчинд идэвхтэй 27,103 хэрэглэгчдийг хамруулжээ. Нэвтрэлтийн түвшин 2019 онд 64 хувьтай байгаа бөгөөд энэ нь 2017 оноос 2 дахин, 2015 оноос 4 дахин өссөн үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлтээс финтекийн талаарх ойлголт дэлхий даяар өндөр байгааг харж болох ба нийт хэрэглэгчдийн 96 хувь нь мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцоог хийх дор хаяж 1 финтек “хувилбар”-тай байна.

Нэвтрэлтийн түвшин хөгжиж буй зах зээл бүхий улсуудын хувьд БНХАУ болон Энэтхэг улсуудад 87 хувьтай тэргүүлж, хөгжингүй зах зээлтэй улсуудаас Нидерланд болон Нэгдсэн вант улсууд харгалзан 73 болон 71 хувь байна.


Бүх төрлийн финтекийн үйлчилгээний талаар хэрэглэгчид ойлголттой ба мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцооны үйлчилгээний хувьд хамгийн сайн мэддэг байна. Энэтхэг болон ОХУ-ын хэрэглэгчдийн 99.5 хувь нь төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлгийн финтек үйлчилгээний талаар мэдээлэлтэй гэсэн үр дүн гарчээ. Үүнийг зах зээл дэх бэлэн мөнгөний эргэлтийг багасгах Энэтхэг улсын Засгийн газрын бодлого болон ОХУ-ын томоохон банкуудад тавьсан хоригоос болж зах зээлд шинээр гарч ирсэн мөнгөн гуйвуулга, гадаад валютын арилжаа эрхлэгчдийн өсөлттэй холбож тайлбарлаж болно.

Зураг 1. Хэрэглэгчдийн ойлголтын түвшин, үйлчилгээний төрлөөр



Эх сурвалж: Global FinTech Adoption Index 2019, EY

Зураг 2. Хэрэглэгчдийн хэрэглээний түвшин, өсөлт; бүтээгдэхүүний төрлөөр




Эх сурвалж: Global FinTech Adoption Index 2019, EY

1 Санхүүгийн технологи

Хэрэглээний түвшин хамгийн өндөр үйлчилгээний хувьд мөн мөнгөн шилжүүлэг, төлбөр тооцооны үйлчилгээ байна. Тус үйлчилгээний нэвтрэлтийн түвшин хамгийн өндөр улс болох БНХАУ-ын хэрэглэгчдийн хувьд голцуу P2P төлбөр тооцоо, банкны бус мөнгөн шилжүүлэг, гар утсаарх төлбөр тооцоо гэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртэж байна. Эдгээр үйлчилгээ түгээмэл байгаа нь 2017 оны тайлангийн үр дүнтэй ижил буюу данс болон бүртгэл үүсгэхэд хялбар юм. Гэсэн хэдий ч P2P зээл, хамтын хөрөнгө оруулалт (equity crowdfunding) зэрэг зарим үйлчилгээний хувьд зах зээлийн зохицуулалтын онцлогоос болоод нэвтрэлт удааширч байна.

Даатгалын салбарын хувьд нэвтрэлтийн түвшин өндөр байгаа нь дэлхий даяарх хэрэглэгчдийн тал орчим хувь даатгалын шимтгэлийг харьцуулах вэбсайт, ухаалаг төхөөрөмжтэй холбогдсон даатгалын бүтээгдэхүүн, P2P даатгал зэрэг бүтээгдэхүүн, үйлчилгээг авч байгаатай холбоотой. Алсын зайны даатгалтай холбоотойгоор машиныг “хар хайрцагжуулах”, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй холбоотойгоор хэрэглэгчдийн гар утсан дахь алхам тоолох аппликэйшн зэрэг нь тус төрлийн үйлчилгээний нэвтрэлтийг түргэсгэж байна.


Зураг 3. Финтекийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх шалтгаан, 2017–2019



Эх сурвалж: Global FinTech Adoption Index 2019, EY

Финтекийн салбар зах зээлд “нутагшсан” эсэхийг үзүүлэх нэг хүчин зүйл бол иргэдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгчдээс чухалчилж буй хэрэгцээг тодруулах юм. 2017 онд финтекийн хэрэглэгчдийн 30 хувь нь данс, бүртгэл нээхэд хялбар, 13 хувь нь харьцангуй бага хүү, шимтгэлтэй гэсэн шалтгаанаар ашиглаж байсан бол 2019 онд эдгээр шалтгаан нь байраа “сэлгэн” харгалзан 20 хувь, 27 хувьтай байна. Судалгааны үр дүнгээс БНХАУ-ын хэрэглэгчдийн хувьд нэвтрэлтийн түвшин өндөр учир данс нээхэд хялбар байх нь тийм ч анхаарал хандуулах шалгаан гэж үзэхээ больсон хэвийн зүйл гэж гарчээ.

Зураг 4. Одоогийн харилцаж буй санхүүгийн байгууллагаар үйлчлүүлж буй шалтгаан, 2017–2019



Эх сурвалж: Global FinTech Adoption Index 2019, EY

Одоогийн харилцаж буй финтек бус санхүүгийн байгууллагаар үйлчлүүлж буй шалтгааны хувьд 2017 онд Финтек компаниудын хэрхэн ажилладаг талаар бага эсвэл ямар ч ойлголтгүй байдал 42 хувьтай байсан нь буурч 34 хувь болсон хэдий ч одоогийн харилцаж буй байгууллагадаа илүү итгэх нь өссөн харагдлаа. Түүнчлэн Чили, Франц, Япон зэрэг улсуудад финтек компаниас илүү уламжлалт санхүүгийн байгууллагаараа үйлчлүүлэх хандлага зах зээлийн нэвтрэлтийн хамгийн том саад болоод байна.




### The Fintech 100:

Олон улсын санхүүгийн мэргэжлийн үйлчилгээний сүлжээ компани болох KPMG-ээс жил бүр гаргадаг “The Fintech100” буюу дэлхий даяар финтекийн салбарт хамгийн шинэлэг санааг гарган, амжилттай үйл ажиллагаа явуулж буй шилдэг 100 компанийн жагсаалтын 2019 оны тайлангаас “Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт оруулж байна.

Fintech100 жагсаалтыг гаргахдаа компаниудын дараах 5 хүчин зүйлсэд тулгуурладаг. Үүнд:

1. Жилийн босгосон хөрөнгө оруулалтын дундаж
2. Хамгийн сүүлд босгосон хөрөнгө оруулалтын хүү
3. Газарзүйн хүчин зүйл
4. Салбарын хүчин зүйл
5. Х-хүчин зүйл буюу бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварын онцлог

### The Fintech 100 includes:



Энэ жилийн Fintech100 жагсаалтад орсон компаниудыг газар зүйн байршлаар нь харвал Ази, Номхон далайн бүс нутгаас 42 компани, Европ, Африк тивүүдээс 36 компани, Хойд болон Өмнөд Америк тивээс 22 компани багтжээ. Харин бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нь харвал:

- 27 – Төлбөр тооцооны, мөнгөн гүйлгээ
- 19 – Хөрөнгө оруулалт
- 17 – Даатгал
- 15 – Зээл
- 9 – Шинэ төрлийн банк (neo-bank)
- 13 – Олон төрлийн финтек үйлчилгээг үзүүлдэг байгууллагууд багтсан байна.

2019 оны шилдэг 5 компанийн талаар товч танилцуулья.

1. **Ant financial** (БНХАУ) – Зах зээлийн үнэлгээ 150 тэрбум ам.доллар (2018–04 сар) – Тогтвортой санхүүжилттэй холбоотойгоор сэтгүүлийн өмнөх дугааруудад нийтлэгдэж байсан Ant financial group тус жагсаалтад тэргүүн байрыг эзэлсэн байна. Өмнө нь Alipay гэдэг

нэртэй байсан тус санхүүгийн байгууллага нь 2014 оны 10 дугаар сард нэрээ Ant Financial Services болгож өөрчилсөн ба технологид суурилсан санхүүгийн хэд хэдэн үйлчилгээг үзүүлдэг. Түүнээс дурдвал, Alipay буюу дэлхийн хамгийн том гар утасны болон онлайн төлбөр тооцооны платформ, MYbank буюу онлайн банк, Ant Fortune гэх хөрөнгийн удирдлагын платформ зэрэг багтана.

Alipay цахим төлбөр тооцооны платформыг өнөөгийн байдлаар (10.01.2019) 1.2 тэрбум гаруй хүн ашиглаж байгаа бөгөөд, 56 гаруй улсад ашиглах боломжтой байна. Тус компанийн аппликэйшнийг ашигласнаар зээл, хадгаламж, P2P шилжүүлэг, хэрэглээний зардлаа төлөх, нийтийн тээврийн хэрэгслийн тасалбар худалдан авах, хоол захиалах, цахим бичиг баримт хадгалах зэрэг төрөл бүрийн үйлчилгээг авах боломжтой.

2019 оны 11 дүгээр сараас эхлэн БНХАУ-д аялаж буй жуулчдад зориулан “Tour pass” үйлчилгээг нэвтрүүлсэн ба тус үйлчилгээний онцлог нь жуулчид өөрийн ашигладаг данснаас Шанхай хотын банкнаас картын үйлчилгээг авах боломжтой болно. Үүнээс гадна тус картыг ашиглах шаардлагагүй бөгөөд бүх төлбөр тооцоог гар утаснаасаа хийх боломжтой. Картыг цэнэглэх доод хэмжээ нь 100 юань, дээд хэмжээ нь 2000 юань ба 90 хоногийн хугацаанд хүчинтэй. Дансны үлдэгдлийг картын хугацаа дуусахад буцаан олгодог байна.

2. **Grab** (Сингапур) – Зах зээлийн үнэлгээ 10 тэрбум ам.доллар (2018–06 сар) Өмнө нь MyTaksi болон GrabTaxi гэдэг нэрээр алдартай байсан Сингапурын хүргэлт үйлчилгээний компани нь жагсаалтын хоёрдугаарт бичигджээ. Хэдийгээр гол үйлчилгээ нь гар утасны аппликэйшнээр дамжуулан ашиглах такси дуудлагын үйлчилгээ боловч нэмэлтээр хоол хүргэлт, онлайн төлбөр тооцооны үйлчилгээг нэвтрүүлсэн. Хамгийн сүүлийн мэдээллээр 36 сая хүн ашиглагдаас өдөр тутам 46 сая гаруй хүргэлт хийгддэг ба дэлхийн 8 улс, 235 хотод ашиглах боломжтой байна.



Grab аппликэйшнийг ашигласнаар GrabPay буюу төлбөр тооцооны үйлчилгээг авах боломжтой. Тус үйлчилгээний давуу тал нь зөвхөн такси хүргэлтийн үйлчилгээний хөлсийг төлөхөөс гадна дэлгүүр, зоогийн газар зэрэг газруудад тооцоо хийхдээ ашиглах, цаашлаад өөр хоорондоо мөнгөн шилжүүлгийг ч хийх боломжтой. Мөн тус аппликэйшнийг ашиглан үйлчилгээ авах тутамд таны дансанд оноо орох бөгөөд тодорхой хэмжээнд хүрвэл оноогоо ашиглан бэлэг авч болдог давуу талтай.

3. **JD Digits** (БНХАУ) – Зах зээлийн үнэлгээ 7.3 тэрбум ам.доллар (2016–01 сар) – 2018 онд нэрээ JD Finance-аас JD Digits болгон өөрчлөн дижитал санхүү, “urban computing”<sup>2</sup>, дижитал хөдөө аж ахуй, дижитал маркетинг, дижитал хөрөнгө удирдлага гэсэн үйлчилгээнүүдийг үзүүлэх болжээ. Хиймэл оюун ухаан, блокчэйн зэрэг шинэ технологиудыг ашиглан санхүүгийн болон бодит үйлдвэрлэлийн салбар дахь зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хамгийн өндөр түвшинд байлгаж, бизнесийн загварыг сайжруулах зорилготой.



2 Urban computing – Хот, суурин зэрэг хүн амын төвлөрөл ихтэй газруудад тулгардаг агаарын бохирдол, замын түгжрэл, эрчим хүчний өндөр зарцуулалт зэрэг томоохон асуудлуудыг шийдэх үүднээс интернет сүлжээ, мэдрэгч, компьютер, зэрэг бусад мэдээллийн хэрэгслүүд, мөн байшин, барилга, машин зэргийн бүх мэдээллийг олж авах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа.

JD Agri-husbandry буюу хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас дурдвал БНХАУ дахь гахай үржүүлгийн том болон дунд компаниудад гаргаж өгсөн хиймэл оюун ухааны “solution” буюу “шийдэл” юм. Хиймэл оюун ухааны тусламжтайгаар хөдөлмөрийн зардлыг 30 хувиар, хоол тэжээлийн зарлыг 8–10 хувиар буюу нийтдээ нэг гахайд ногдох зардлыг 80 юаниар бууруулж чадсан байна. Ингэснээр гахай үржүүлгийн компанийн ашгийг хамгийн өндөр түвшинд хүргэх боломжийг бүрдүүлжээ.



4. **GoJek** (Индонез) – Зах зээлийн үнэлгээ 10 тэрбум ам.доллар (2019–04 сар) – Анх 2010 онд бараа хүргэлт болон моторт дугуйн

хүргэлтийн үйлчилгээгээр үйл ажиллагааг эхлүүлж байсан ба өнөөгийн байдлаар аппликэйшний тусламжтайгаар Зүүн өмнөд Азийн 5 улсад такси, хүнс болон эмийн хүргэлт, төлбөр тооцоо, засвар, хувцас цэвэрлэгээ зэрэг 20 гаруй төрлийн үйлчилгээг авах боломжтой байна.

GoPay нь Индонезийн 4 дэхь том цахим хэтэвчийн үйлчилгээ боловч 2017 оны эцсийн байдлаар улсын нийт цахим мөнгөний гүйлгээний 30 хувийг нь GoPay –ээр дамжуулан гүйцэтгэжээ.

5. **Paytm** (Энэтхэг) – Зах зээлийн үнэлгээ 18 тэрбум ам.доллар (2019–03 сар) – Paytm нь 2010 онд байгуулагдсан Энэтхэгийн цахим худалдаа, төлбөр



тооцоо, санхүүгийн үйлчилгээний компани юм. Өдөр тутмын хэрэглээний зардлаас эхлээд сургалтын төлбөр, иргэд хоорондын шилжүүлэг, түүнчлэн 1 рупитэй тэнцэхүйц хэмжээний алт, хувьцаа зэрэг хөрөнгө оруулалтыг хийх боломжтой юм.

## СУДЛААЧИЙН ИНДЭР



### САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ҮҮСЭХ СИСТЕМИЙН ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО (МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛД)

СУДАЛГАА, ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН **Н.НАРАНТУЯА**

**Хураангуй:** Энэхүү судалгаа нь санхүүгийн зах зээлийн хөгжлийн шатандаа орж буй улс буюу Монгол дахь санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлийг тайлагналд тусгасан тоон мэдээг ашиглан үнэлэхийг зорьсон. FTSE–ийн судалгаагаар 200 гаруй улсын санхүүгийн зах зээл дөнгөж хөгжлийн шатандаа орж байгааг онцолсон байдаг тул эдгээр улсуудын жижиг хэмжээний эрсдэлүүд бөөгнөрсөөр системийн эрсдэлийг үүсгэж эдийн засгийн тогтворгүй байдлыг алдагдуулах талтай. Санхүүгийн зах зээлийн хөгжлийн шатандаа орж буй улс орнуудад урьдчилан

таамаглагдаагүй системийн эрсдэл буюу Леман Бродерс (Lehman Brothers)–ын шокын эрт анхааруулгыг таних боломжгүй байсан шиг нуугдаж байх магадлал бий. Эдгээр зах зээлийн системийн эрсдэлийг үнэлээгүй байгаа нь системийн хувьд ач холбогдолгүй гэж үзсэн эсвэл олон нийтэд хүртээмжтэй тоон мэдээ дутагдалтай байдгаас улбаатай.

Зарим тохиолдолд хөгжлийн шатандаа орж буй зах зээлийг жижиг буюу нөлөөлөл багатайн улмаас системийн хувьд ач холбогдолгүй гэх тохиолдол байх ч санхүүгийн байгууллагуудын хоорондох холбоо хамаарал системийн эрсдэлийг үүсгэх өндөр магадлалтайг судалгаагаар баталсан. Үнэндээ хөгжингүй, хөгжиж буй, хөгжлийн шатандаа орж буй бүх санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд хоорондоо өр, авлагын гинжин хэлхээгээр холбогдсон байдаг. Монгол Улсын санхүүгийн зах зээл ОУВС–аас тодорхойлсны дагуу хөгжлийн үе шатандаа орж байгаа улс орнуудын нэг. Санхүүгийн зохицуулалт талаас нь харахад банк давамгайлсан, хөрөнгийн зах зээл нь хөгжиж байгаа манай улсад санхүүгийн групп компаниудын тоо

нэмэгдэж, тэдгээрийн хоорондын холбоо хамаарал гүнзгийрч байна. Тиймээс санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх санхүүгийн хуйвалдааны цаана нуугдаж буй системийн тодорхойгүй байдлыг илрүүлэх шаардлага бий. Гол чиглэл нь санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлд нөлөөлөх байдлыг тооцох юм.

Санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлийн нөлөөллийг системийн хувьд хүлээгдэж буй алдагдлаар тооцооллоо. Системийн хувьд хүлээгдэж буй алдагдал нь ахуйц хүлээгдэж буй алдагдал, санхүүгийн хөшүүргийн болон өр төлбөрийн харьцаа зэрэг хувьсагчдаас хамааралтай болно. Түүнчлэн санхүүгийн тайлан нь байгууллагын нөхцөл байдлыг илтгэдэг. Эдгээр таамаглалд үндэслэн системийн эрсдэлийн цаг хугацааны болон хөндлөн нөлөөллийг хэмжлээ. Системийн эрсдэлийг таамаглах хувьсагчдыг санхүүгийн тайлангаас бүрдүүлэхийн тулд боломжит тоон өгөгдлүүдээс хамгийн өндөр хамааралтайг сонгосон. Учир нь системийн эрсдэлийг тооцсон байгаа судалгаануудад хувьцааны өгөөжийн мэдээг ашигласан байдаг бол санхүүгийн тайланг ашиглан

системийн эрсдэлийг тооцож буй нь шинэлэг юм.

Судалгааны үр дүнгээс системийн хүлээгдэж буй алдагдал хөндлөнгийн буюу санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлд нөлөөлж буй байдлыг тайлбарлаж чадсан бөгөөд ахиуц хүлээгдэж буй алдагдлын хугацааны цуваан өгөгдөл ирэх хоёр улирлын системийн эрсдэлийн хэмжээг таамаглахаар байна. Санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлийн нөлөөллийг таамагласнаар системийн эрсдэлийг удирдах бодлогын хэрэгсэл болох макро зохистой бодлогын аль төрлийг хэрэгжүүлэх нь тодорхой болдог.

Түлхүүр үгс: системийн эрсдэл, макро зохистой бодлого, системийн хүлээгдэж буй алдагдал, ахиуц хүлээгдэж буй алдагдал, санхүүгийн хөшүүрэг, хамгийн их алдагдлын арга, хүлээгдэж буй алдагдал

### 1. Судалгааны ажлын зорилго

Санхүүгийн зах зээлийн хөгжлийн үе шатандаа орж буй улс орнуудын төлөөлөл болох Монгол дахь санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлийн нөлөөллийг үнэлэхийг зорьлоо. Үнэлгээний үр дүнгээс макро зохистой бодлогыг тохиромжтойгоор боловсруулахыг чиглэсэн.

Судалгаандаа системийн хүлээгдэж буй алдагдал, ахиуц хүлээгдэж буй алдагдал, санхүүгийн хөшүүргийн болон өр төлбөрийн харьцаа гэсэн хувьсагчдыг ашиглан олон хүчин зүйлийн регресс үнэлсэн.

### 2. Санхүүгийн тогтвортой байдал болон системийн эрсдэлийн тухай

*Санхүүгийн тогтвортой байдал:* Санхүүгийн зах зээл нь боломжит хөрөнгө оруулалтад үр ашигтайгаар хөрөнгийг хуваарилснаар эдийг засгийн өсөлтийг түргэтгэдэг функц. Энэхүү функцийг урт хугацаанд тогтвортойгоор хадгалахын тулд санхүүгийн зах зээл, түүн доторх байгууллагууд нь гадны шокын хүчийг сулруулах, халдварлах нөлөөнд уян хатан байх, түүнчлэн оролцогчдын итгэх итгэл чухал юм.

*Системийн эрсдэл:* Системийн эрсдэл нь цаг хугацааны, хөндлөнгийн нөлөөлөл болон гадаад хугалдааны мөнгөн урсгалаас үүсч болдог. Тухайлбал:

- Эдийн засгийн мөчлөгийн уналтын үе
- Мэдээллийн тэгш бус байдал
- Даяарчлал

- Санхүүгийн либералчлал
- Зохицуулалтад ороогүй санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүд
- Санхүүгийн зах зээл хоорондын шууд болон шууд бус холбоо хамаарал
- Санхүүгийн группүүд

Системийн эрсдэл нь санхүүгийн байгууллагуудыг уналтад оруулаад зогсохгүй хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг удаашруулдаг тул эдийн засагт нийлүүлэх мөнгөний хэмжээг бууруулдаг. (Acharya, 2016)

*Макро зохистой бодлого:* Системийн эрсдэлийг удирддаг бодлогын хэрэгсэл бөгөөд санхүүгийн, цаашлаад эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад мөнгөний болон сангийн бодлого, микро зохистой бодлогоор хэрэгжүүлж чаддаггүй орон зайг нөхдөг.

### 3. Судлагдсан байдал

Системийн эрсдэлийг үнэлэх, макро зохистой бодлогыг боловсруулах чиглэлээр олон улсын зохицуулалтын байгууллагууд болох Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Базелын хороо, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага, Даатгалын хяналт шалгалтын олон улсын байгууллагууд стандарт, зөвлөгөө гарган ажилладаг. Харин Олон улсын валютын сан болон судлаачид уг эрсдэлийг үнэлэх, төрийн бодлогуудтай уялдуулах, засаглалыг сайжруулах зэрэг ажлууд судлагдаж байна. Мөн хөгжсөн болон хөгжиж буй санхүүгийн зах зээлүүдэд макро зохистой бодлого хэрэгжээд 10 жилийн туршлагатай болсон тул үр дүнг үнэлж эхэлсэн. Харин хөгжлийн шатандаа орж буй зах зээлүүдэд хэрхэн системийн эрсдэлийг үнэлж макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх тухай асуудал хэлэлцэгдэж байна.

Санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлд нөлөөлөх байдлыг үнэлэх хэд хэдэн аргачлал байдаг. Үүнд:

- Нөхцөлт хамгийн их алдагдал
- Харьцангуй үнэлгээний онол
- Стресс тест
- Нөхцөлт авторегрессийн хамгийн их алдагдлын аргууд болно.

Эдгээр судалгаанууд нь хөгжсөн зах зээлд хийгдсэн буюу хөрөнгийн зах зээлийн нээлттэй мэдээллүүдийг ашигласан байдаг. Гэвч хөгжлийн шатандаа орж буй зах зээлийн хөрөнгийн зах зээлд хангалттай хэмжээний санхүүгийн байгууллагууд хувьцаа

арилжаалдаггүй тул тоон мэдээллийн олдоц бага тул судалгаа хийхэд хүндрэлтэй байдаг.

### 4. Судалгааны аргачлал

Системийн эрсдэл тохиолдсон үед Засгийн газраас уналтанд орох гэж буй санхүүгийн байгууллагуудыг хамгаалахын тулд төсвөөс санхүүжилт гаргадаг учраас эдийн засагт хохиролтой байдаг (Acharya, 2016). Харин үүний эсрэг системийн эрсдэлийн үед зарцуулах нөөц сан байгуулснаар хамгаалж болно. Санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлд нөлөөлж буй байдлаас нь хамааран нөөц санг хураамжийн тогтолцоогоор бүрдүүлнэ гэсэн санааг дэвшүүлье.

Санхүүгийн байгууллагын эрсдэлийг тооцох хамгаалалтын функцийн загварыг дараах байдлаар томъёолбол:

Зохицуулагч хамгаалалтын функцийг хамгийн өндөр түвшинд байлгахыг зорино.

$$p^1 + p^2 + p^3 \quad (\text{Тэгшитгэл 1})$$

Санхүүгийн байгууллагуудын эздийн өмчийн нийлбэр:

$$p^1 = \sum_{i=1}^N c(w_0^i - w_0^i - \text{tax}) +$$

$$E(\sum_{i=1}^N u^i (1_{[w_1^i > 0]} * w_1^i)) \quad (\text{Тэгшитгэл 2})$$

Тэгшитгэл 2-оос санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгөөр эрсдэлээ даах хэмжээ харагдаж байна.

Өрийн даатгалын хүлээгдэж буй өртөг:

$$p^2 = E[g * \sum_{i=1}^N 1_{[w_1^i < 0]} \alpha^i w_1^i] \quad (\text{Тэгшитгэл 3})$$

Тэгшитгэл 3-аас санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгөөр өр төлбөрөө төлөх чадваргүй байх үеийн дахин санхүүжилтийн хэмжээ

Санхүүгийн хямралын нөлөө

$$p^3 = E[e * 1_{[w_1 < zA]} * (zA - W_1)] \quad (\text{Тэгшитгэл 4})$$

Тэгшитгэл 4-өөс санхүүгийн байгууллагуудын системийн эрсдэлд нөлөөлөх түвшинг тооцоолох таамаглал гарч ирнэ. Уг нөлөөллийг системийн хувьд хүлээгдэж буй алдагдлыг ахиуц хүлээгдэж буй алдагдал болон санхүүгийн хөшүүргийн харьцаанаас хамааруулан тооцно.

$$SES = b_1 * MES + b_2 * LVG \quad (\text{Тэгшитгэл 5})$$

$$MES_{5\%}^I = -E\left[\frac{w_1^I}{w_0^I} - 1 \mid I_{5\%}\right] \quad (\text{Тэгшитгэл 6})$$

5. Эмпирик судалгаа

Банк давамгайлсан манай улсын санхүүгийн зах зээлд 2011 оноос арилжааны банкуудыг зөвхөн банкны салбарт дагнан эрхлэх үйл ажиллагаанаас банкнаас бусад санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа хавсран явуулах хууль эрхзүйн орчныг бүрдүүлсэн. Үүнээс хойш санхүүгийн байгууллагууд маш идэвхтэйгээр хөрөнгийн зах зээл, даатгал төдийгүй бичил санхүүгийн салбарт охин компаниараа дамжуулан үйл ажиллагаагаа явуулах болсноор санхүүгийн группүүд үүссэн. Банк давамгайлсан санхүүгийн зах зээлтэй манай улсад арилжааны банкууд бусад салбар луу орсноор тэдгээрийг хөгжүүлэх давуу талтай. Гэхдээ үүний цаана нуугдаж буй санхүүгийн төвлөрөл, хоорондын холбоо хамаарлаас үүдэлтэй системийн эрсдэлийг удирдсанаар тогтвортойгоор хөгжих юм.

*Шинжилгээний хэсэг:* Жижиг эрсдэлүүд урт хугацааны туршид бөөгнөрсөөр эдийн засгийн мөчлөгийн хөмрөлтийн үед хагардаг ба үүнийг цаг хугацааны системийн эрсдэл гэнэ. Энэ төрлийн эрсдэлийг үнэлэхээр ахиуц хүлээгдэж буй алдагдлын хугацааны цуваан регресс үнэллээ. Хугацааны цуваан түүвэр нь 2006 оноос 2017 он хүртэлх нийт 43 улирлын тоон мэдээг хамруулсан болно.

Ахиуц хүлээгдэж буй алдагдлыг зээлийн эрсдэлээр төлөөлүүлэн тооцсон ба үүнд арилжааны банк, ББСБ болон ХЗХ-дын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийлбэрээр хэмжсэн.

График 1-д харуулсанчлан хугацааны цуваан тренд нь дээшээ чиглэлтэй бөгөөд өсөлт нь тогтмол бус байна.

График 1. Ахиуц хүлээгдэж буй алдагдал




p-value 0.9987

Dickey-Fuller test 2.018

Харин хугацааны цувааны хоёр хоцрогдолтой үед тренд жигд болж байна.

График 2. Ахиуц хүлээгдэж буй алдагдлын хоёр дахь хугацааны хоцрогдол




p-value 0

test statistic -6.739

Засварлагдсан тоон өгөгдөл нь автокорреляцитай буюу ахиуц хүлээгдэж буй алдагдал нь өмнөх хугацаанаасаа хамааралтайг илтгэж байна.

График 3. Авторегрессийн өмнөх автокорреляци



Хугацааны цуваа нь автокорреляцитай учраас тухайн хугацаан дахь үр дүнд аль хугацаа нөлөөтэй байгааг ARMA загвараар тооцлоо. Тооцооллын үр дүнд ахиуц хүлээгдэж буй алдагдал нь дараах хоёр улиралдаа нөлөөлдөг ба хүснэгт 1-т харуулснаар богино хугацааны шокод нөлөөгүй байна.

Хүснэгт 1. Хоёрдугаар зэргийн авторегресс

Хувьсагч: Ахиуц хүлээгдэж буй алдагдал

	Детерминацийн коэффициент	Стандарт алдаа
Тогтмол утга	636.38 (0.07)	8897.01
L1	-0.18 (-1.30)	0.14
L2	-0.57 (-5.07)	0.11
$\sigma$	80435.97 (10.11)	7957.76

*Хөндлөн тоон мэдээн шинжилгээ:* Хөгжсөн зах зээлд ахиуц хүлээгдэж буй алдагдлыг хувьцааны өгөөжөөр тооцдог. Харин манай улсад цөөхөн тооны санхүүгийн байгууллагууд хувьцаагаа олон нийтэд арилждаг тул хөрөнгийн зах зээлийн тоон мэдээ хангалтгүй байдаг. Иймд санхүүгийн байгууллагын хөрөнгө нь эх үүсвэрээсээ багассан үед дампуурах магадлал ихэснэ гэсэн таамаглалд үндэслэвэл санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн хүлээгдэж буй алдагдлыг төлөөлүүлэн тооцож болно.

Хөндлөн тоон шинжилгээний үнэлгээг арилжааны банк, даатгал, ББСБ, ХЗХ-дын 2009, 2013 болон 2017 онуудын тоон мэдээнд өмнөх оноос нь хамааруулан тооцсон.

а) *2009 оны системийн хүлээгдэж буй алдагдал:* Монгол улсын эдийн засаг 2009 онд дэлхийн эдийн засгийн хямралын улмаас уналтад орсон. Үүний үр дүнд валютын ханш чангарч, арилжааны нэг банк чанаргүй зээлийн улмаас дампуурсан байдаг.

Системийн хүлээгдэж буй алдагдлыг ахиуц хүлээгдэж буй алдагдал, санхүүгийн хөшүүргийн болон өр төлбөрийн харьцаанаас хамааруулан үнэлэхэд:

Хүснэгт 2: Регрессийн үр дүн /2009 он/

	ББСБ	Банк	ХЗХ	Даатгал
t-statistic	0.89	-0.15	0.86	1.19
Adj R <sup>2</sup>	0.48	-0.07	0.52	0.98

Регрессийн үр дүн ББСБ, ХЗХ болон даатгалын салбарын ач холбогдлын түвшин өндөр гарсан. Харин банкны салбарт ач холбогдолгүй гарсан нь санхүүгийн тайлангийн тоон мэдээллийн олдоц бага байсантай холбоотой.

b) 2013 оны системийн хүлээгдэж буй алдагдал: 2010 оноос уул уурхайд суурилсан эдийн засгийн өсөлт 2013 онд эргэн удааширнаар зээлийн эрсдэл нэмэгдсэн.

Мөн арилжааны банкуудын зээлийн шаардлага нэмэгдсэнээр ББСБ-уудын үйл ажиллагаа эрхлэх эрэлт нэмэгдсэн. Уул уурхайн түүхий эдийн үнэ огцом унаснаар хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилждаг компаниудын хувьцааны үнэ огцом унасан.

Хүснэгт 3: Регрессийн үр дүн /2013 он/

	ББСБ	Банк	ХЗХ	Даатгал
t-statistic	0.27	1.19	0.67	0.5
Adj R <sup>2</sup>	0.003	0.68	0.93	0.72

2017 оны системийн хүлээгдэж буй алдагдал:

Хүснэгт 3: Регрессийн үр дүн /2017 он/

	ББСБ	Банк	ХЗХ	Даатгал
t-statistic	-10.14	6.58	0.28	1.18
Adj R <sup>2</sup>	0.226	0.64	0.01	0.81

## 6. Дүгнэлт

Санхүүгийн зах зээл нь хөгжсөн, хөгжиж буй болон хөгжлийн үе шатандаа орж буй гэж ангилагддагаас макро зохистой бодлого хэрэгжсэн нь эхний хоёр зах зээл юм. Хөгжсөн эдийн засагтай орнуудын үйл ажиллагаа бусад улс орнуудад ихээр нөлөөлдөг. Иймд ихэнх судлаачид эдгээр улсуудын системийн эрсдэлийг үнэлэхэд анхаарсан. Харин хөгжлийн шатандаа орж буй зах зээлд банк давамгайлсан, хөрөнгийн зах зээл хөгжөөгүйн учраас тоон мэдээлэл бага, мөн дангаараа дэлхий дахинд бага нөлөөлөлтэй байдаг тул энэ төрлийн судалгаа хийгдээгүй байна.

Иймд хөгжлийн шатандаа орж буй зах зээлийн системийн эрсдэлийг үнэлэхийг зорьсноороо энэхүү судалгааны ажил нь шинэлэг байв. Энэ төрлийн зах зээлийн системийн эрсдэлийг эрт үед нь үнэлээд удирддаг болсноороо эрсдэлийн эсрэг дархлааны тогтолцоо бий болох давуу талтай.

Цаг хугацааны системийн эрсдэлийн нөлөө ирэх хоёр улиралдаа нөлөөлдгийг хугацааны цуваан регрессийн шинжилгээ харууллаа.

Хөндлөнгийн системийн эрсдэлийн ирэх нэг улирлын нөлөөллийг мөн тооцоолох боломжтой байна. Тооцооллын үр дүнг сайжруулахын тулд балансын гадуурх дансны бүртгэлд ач холбогдол өгч, мөн хөлгөн тоон өгөгдлийн мэдээллийн санг бүрдүүлэх шаардлагатай.



## ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД

### УХААЛАГ ШИЙДВЭР ГАРГАЛТ, УХААЛАГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалт нь улс орны санхүү, эдийн засгийн хамгийн том хүчин зүйлсийн нэг тул дэлхийн хөгжингүй улс орнууд иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, ухаалаг шийдвэр гаргахад туслах зорилгоор санхүүгийн боловсролыг нийгмийн харилцаанд оролцож буй хүн бүрт олон нийтийн суваг, сонин хэвлэл, социал медиагаар дамжуулан хүргэх болжээ. Хүмүүс заримдаа тухайн зүйлсийн харагдах байдал, өөр хэн нэгнээс сонссон зүйлс эсвэл итгэл үнэмшил зэрэг бодит бус зүйлд үндэслэн хэрэгцээгүй худалдан авалт, ашиггүй хөрөнгө оруулалт хийх нь олонтаа. Сүүлийн жилүүдэд мэдээлэл технологи, социал мэдээллийн сувгууд асар хурдацтайгаар хөгжихийн хэрээр хүмүүсийн санхүүгийн ухаалаг шийдвэр гаргалтад асар ихээр нөлөөлөх болсон. Учир нь өдөр тутамд социал медиа болон бусад мэдээллийн сувгаар дамжин хэрэглэгчдэд очиж буй мэдээлэл нь харилцан адилгүй бөгөөд ихэвчлэн хуурамч, худал мэдээлэл элбэг байдаг. Тухайн хуурамч мэдээлэл нь иргэдийг төөрөгдүүлдэг тул үүнээс сэргийлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүднээс хөгжиж буй улс орнууд иргэдээ энэ төрлийн мэдээлэлд төөрөгдөхгүй байх, энэ төрлийн мэдээллээс хол байлгах зорилгоор санхүүгийн боловсролыг шат шатанд нь анхаарч авч үздэг байна.



Ухаалаг шийдвэр гаргалт бол та тухайн бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх болон бусад санхүүгийн аливаа шийдвэр гаргахын өмнө дахин нэг нягталж энэхүү шийдвэр гаргалт нь зайлшгүй надад хэрэгтэй зүйл мөн бил үү эсхүл энэхүү шийдвэрийг гаргаснаар миний санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлөх боломжтой талаар дахин нэг тунгаан бодохоос эхлэлтэй. Ухаалаг шийдвэр гаргалт нь ухаалаг хөрөнгө оруулалтын эхлэл юм. Учир нь хөрөнгө оруулалт гэдэг нь таны санхүүгийн нөхцөл байдлыг ирээдүйд учирч болох эрсдэлээс хамгаалах, ирээдүйд хэрэглэх хэрэгцээг хангах зорилгоор хийгддэг чухал шийдвэр гаргалт юм. Энэхүү шийдвэр гаргалт нь микро түвшинд өрхийн санхүүгийн ирээдүйн хэрэглээний баталгаа болдог бол макро түвшинд улс орны цаашдын хөгжлийн чиг хандлага, хөгжлийн хурдцыг хэмжих чухал

үзүүлэлтийн нэг болдог. Ухаалаг хөрөнгө оруулалтын хамгийн анхны зарчим бол орлого, зарлагаа тооцон хэрэгцээгүй, ойрын хугацаанд заавал шаардлагатай зүйл биш бол тухайн худалдан авалтаа хийхээс татгалзан орлогынхоо тодорхой хувийг хуримтлал эсвэл хувьцаа, бонд, болон бусад санхүүгийн урт хугацаанд өгөөжөө өгөх хэрэгсэлд хөрөнгө оруулахад төлөвлөх нь юм. Дараагийн зарчим бол та орлогынхоо тодорхой хэсгийг хөрөнгө оруулалт, хуримтлалд оруулахаар төлөвлөсөн бол мэргэжлийн санхүүгийн зөвлөгч, хөрөнгө оруулалтын сан, болон санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас хэрхэн хөрөнгө оруулалт хийх, хэдий хэмжээний өгөөжийг хичнээн хугацааны дараа хүртэх боломжтой талаар судлах хэрэгтэй. Гурав дахь зарчим бол та ямар санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахын тулд тухайн санхүүгийн зөвлөгөө өгсөн мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөөнд тулгуурлан өөрийн хөрөнгө оруулалтын одоогийн үр өгөөж болон ирээдүйд авах үр өгөөжийг тооцон ямар санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх талаар сонголт хийнэ.



Таны хөрөнгө оруулалт бүр танд өгөөжөө харилцан адилгүй өгөх бөгөөд заримдаа эрсдэл учрах тохиолдол мөн гарч болзошгүй байдаг. Тиймээс ирээдүйд орж ирэх хөрөнгө оруулалтад бүрэн дүүрэн итгэлтэйгээр зардлын хэмжээгээ нэмэгдүүлэх эсвэл тухайн хөрөнгө оруулалтын өгөөж хүлээлтээс их эсвэл бага байх үед яаран зардлаа огцом нэмэгдүүлэх, эсвэл хэрэгцээгүй зардлаа огцом нэмэгдүүлэх нь таны санхүүг эргээд эрсдэлд оруулах магадлалтай. Таны өнөөдөр гаргаж буй шийдвэр болгон тань ирээдүйн сайн сайхан байдал, санхүүгийн чадамжид тань нөлөөлж байдаг тул аливаа шийдвэр гаргахын өмнө одоо болон ирээдүйг харгалзан тунгаан шийдвэр гаргах нь бат бөх санхүүгийн эх үүсвэртэй байхын эхлэл, үргэлжлэл гэдгийг байнга санаж явах нь чухал.

## ӨРГӨН ДУРАН

### **“Азийн санхүүгийн байгууллагын форум 2019” анхны чуулга уулзалтад амжилттай оролцлоо. /2019.01.22–23/**

Тайландын Вант Улсын Бангкок хотноо 2019 оны 01 дүгээр сарын 22–оос 23–ны өдрүүдэд Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс Ази дахь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд салбартаа тэргүүлэгч хөгжлийн санхүүгийн байгууллагууд болон нөлөө бүхий хөрөнгө оруулагчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго бүхий “Азийн санхүүгийн байгууллагын форум 2019” анхны чуулга уулзалт зохион байгуулагдсан. Тус форумтаар өрийн хэрэгслээр дамжуулан хөрөнгө босгох, хувьцаагаар хөрөнгө оруулалт хийх, техник тусалцааны хөтөлбөр хэрэгжүүлэх боломжуудын талаар нэгдсэн хэлэлцүүлэг, Азийн улс орнуудын эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчны талаар дэд хэлэлцүүлгүүд тус тус болж өнгөрсөн.

Уулзалтад 39 улсын 194 хөрөнгө оруулагчид, 302 хөрөнгө оруулалт татах сонирхолтой аж ахуйн нэгжүүд, 50 гаруй бодлого зохицуулалтын байгууллагууд болон санхүүгийн байгууллагуудаас төлөөлөн ирсэн панелистууд оролцсон. Санхүүгийн зохицуулах хорооны хувьд Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн талаарх дэд хэлэлцүүлэгт панелистаар оролцсон бөгөөд тус хуралдаанаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт, ирээдүйн чиг хандлагын талаарх хүлээлт, тогтвортой өсөлтийг хангах үл хөдлөх хөрөнгийн зах зээл болон бусад дэд сектор дахь хөрөнгө оруулалтын боломж, түүнчлэн санхүүгийн салбар дахь хүртээмжтэй өсөлтийг хэрхэн хангах талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.

### **“СХН–ийн бодлого тодорхойлогчдын дээд хэмжээний чуулга уулзалт”–ын хуралдаанд Санхүүгийн зохицуулах хороо удирдах түвшинд оролцлоо. /2019.3.01/**

Олон Улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /СХН, The Alliance for Financial Inclusion, AFI/–ийн бодлого тодорхойлогчдын дээд хэмжээний чуулга уулзалт Бүгд Найрамдах Котд’Ивуар Улсын Абиджан хотноо 2019 оны 3 дугаар сарын 01–ний өдөр зохион байгуулагдсан. Санхүүгийн зохицуулах хороо 2009 онд тус нийгэмлэгт гишүүнээр элссэн бөгөөд 2016 оноос хойш Хорооны төлөөлөл нийгэмлэгийн бүх буюу долоон ажлын хэсэгт ажиллаж байна. Энэ удаагийн чуулганы “Санхүүгийн хүртээмжийн ирээдүйг шинэчлэх нь” сэдэвт хуралдааныг Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны удирдлага ахалла.

Тус хуралдаанаар банк, санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй 1.7 тэрбум хүмүүст санхүүгийн үйлчилгээг хүргэх стратегийг төлөвлөх, цаашид хүртээмжтэй санхүүг ямар чиг хандлагаар өргөжүүлэн хөгжүүлэхийг тодорхойлох, холбогдох зохицуулалт болон зөвлөмжүүдийг боловсруулах зэрэг өргөн хүрээний асуудлуудыг хэлэлцэв. Түүнчлэн хөгжиж буй болон хөгжингүй орнуудад тулгарч буй санхүүгийн хүртээмж дэх жендерийн тэгш бус байдлыг багасгах арга зам, тэдгээрийн шийдлүүдийг эрэлхийлж, технологийн дэвшилд суурилан санхүүгийн хүртээмжийг тэлэх боломж, гарцуудын талаар хэлэлцэн, гишүүн улс орнуудын төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагуудад хандан дээрх асуудлуудаар зохих зөвлөмжийг өгөхөөр боллоо.

### **Хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд газар дээрх иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэлээ. /2018.10–2019.01/**

2018 оны 10 дугаар сараас 2019 оны 01 дүгээр сарын хооронд нийт хөрөнгийн хэмжээгээр томоохонд тооцогдох 10 ХЗХ–ны үйл ажиллагаанд газар дээрх иж бүрэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Шалгалтад хамрагдсан системд нөлөө бүхий ХЗХ–дод газар дээрх шалгалтаар засаглалын хангалтгүй байдал, дансны үлдэгдлүүдийн зөрүү, зээлийн хувийн хэргийн дутуу бүрдэл, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”, “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар”–ын хэрэгжилтийн дутмаг байдал зэрэг нийтлэг зөрчил, дутагдал ажиглагдаж байна.

Шалгалтад хамрагдсан 9 ХЗХ–нд Хорооны 2018 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”–ын хавсралт болох үнэлгээний аргачлалын дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийж буй үйл ажиллагааг дүгнэхэд 2 ХЗХ бага эрсдэлтэй, 4 нь дунд эрсдэлтэй, харин 3 нь өндөр эрсдэлтэй гэж дүгнэгджээ.

ХЗХ–дын үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайлан, холбогдох дүгнэлтийг ХЗХ тус бүрээр гаргаж, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд арилгуулах талаар үүрэг даалгаврыг ажлын хэсгээс өгөв.

### **“Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг–2019”–ыг амжилттай зохион байгууллаа. /2019.6.17/**

Энэхүү хэлэлцүүлэг нь “Бизнесийн ёс зүй ба комплаенс”, “Комплаенс ба мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг” гэсэн хоёр үндсэн хэсэгтэй байсан ба оролцогчид “Санхүүгийн салбарын ёс зүй болон комплаенсын өнөөгийн байдал”, “Бизнесийн ёс зүй комплаенсын үндэс болох нь”, “Санхүүгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа”, “Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (FATF)–ын Ази номхон далайн бүс нутаг хариуцсан бүлгээс (APG) өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын явц” зэрэг олон сонирхолтой илтгэлийг хэлэлцүүлээ.



“Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг-2019”-д Азийн сан, Монголбанк, Сангийн яам, ГХЯ, ХЗДХЯ, ТЕГ, ОУВС, Дэлхийн банк, АХБ, ЕСБХБ, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын ББСБ-уудын холбоо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо, Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо, Монголын банкны холбоо зэрэг олон газрын төлөөлөгч оролцож санал солилцлоо.

**Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн ээлжит “Дэлхийн бодлогын чуулган”-д Монгол Улс амжилттай оролцлоо. /2019.9.09-13/**



Олон Улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс жил бүр зохион байгуулдаг Дэлхийн бодлогын ээлжит чуулган (Global Policy Forum) Бүгд Найрамдах Руанда Улсын нийслэл Кигали хотноо 9 дүгээр сарын 09-өөс 13-ны өдрүүдэд болж дэлхийн 92 улсын 100 гаруй гишүүн байгууллагын 800 гаруй оролцогчид хурал чуулав.

Дэлхийн бодлогын 2019 оны чуулганыг “Технологоор дамжуулж эмэгтэйчүүд болон залуучуудын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулсан бөгөөд Дижитал санхүү, Ногоон санхүү, Санхүүгийн шинэ технологи (Финтек)-ийн шийдлүүд, тэдгээрийн зохицуулалтын технологи (Рэгтек) зэрэг санхүүгийн хүртээмжийн олон талт асуудлуудыг хэлэлцэж, гарцыг эрчимтэй эрэлхийлсэн нь үйл ажиллагааг улам үр нөлөөтэй болгосон.

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо нь 2009 онд тус нийгэмлэгт үндсэн гишүүнээр элссэн бөгөөд 2016 оноос “Хэрэглэгчийг чадавхжуулах, зах зээлийг зохицуулах”, “Дижитал санхүүгийн үйлчилгээ”, “Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдөл”, “Санхүүгийн хүртээмжийн стратеги”, “Олон улсын стандартыг зохистой хэрэгжүүлэх”, “ЖДҮ-ийн санхүүжилт”, “Хүртээмжтэй ногоон санхүү” зэрэг нийгэмлэгийн бүх ажлын хэсэгт идэвхтэй ажиллаж ирлээ.



Уг чуулганы эхний өдөр бүс нутгийн хэмжээнд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах,

санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготойгоор байгуулагдсан Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санаачилгын зөвлөл /ЗЕТАБНСЗ, Eastern Europe & Central Asia Policy Initiative, ЕСАPI/-ийн ээлжит уулзалт болж өнгөрсөн бөгөөд уулзалтаар гишүүн орнуудын төлөөлөл дижитал санхүү, санхүүгийн шинэ технологийн тусламжтайгаар санхүүгийн хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх чиглэлээр өөрсдийн сайн туршлагаасаа харилцан санал солилцож, ирэх жилийн ажлын төлөвлөгөөг хамтран хэлэлцэв.

Түүнчлэн чуулганы хоёр дахь өдөр тус нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн 17 дахь ээлжит хуралдаан болон бүх ажлын хэсгийн хурал давхар эхэлсэн. Үүнд, Захирлуудын зөвлөл нь нийт есөн гишүүнтэй бөгөөд дэлхийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах стратеги, бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд гишүүн орнуудын оролцоог хангах, гүйцэтгэх удирдлага, зөвлөл хорооны гишүүдийг томилж, батлах, үнэлгээ өгөх болон олон улсын санхүүгийн хүртээмжийн талаарх бүхий л хамтын шийдвэрийг баталгаажуулах чиг үүрэгтэй.

Уг Захирлуудын зөвлөлийн ээлжит хурлаар СХН-ийн үйл ажиллагаа, зардал, санхүүжилтийн тайлан, “Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдөл”, “Дижитал санхүүгийн үйлчилгээ” ажлын хэсгүүдээс боловсруулсан “Хүртээмжийн тоон өгөгдлийн үндсэн бүрэлдэхүүн”, “Цахим мөнгөний бодлого” зэрэг баримт бичгүүд, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн оффисыг Европ тивд байгуулах болон удирдах зөвлөлийн удирдамж, төсөв, үйл ажиллагаатай холбоотой менежментийн асуудлуудыг шийдвэрлэв.



Кигалигийн Дэлхийн бодлогын чуулганы үйл ажиллагааны үеэр Монгол Улсын оролцоо өндөр байгааг талууд илэрхийлж байлаа. Ялангуяа санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд манай улсад харьцангуй дээгүүр, данс эзэмшилт зэрэг зарим үзүүлэлтээр хөгжсөн орнуудын түвшинд явж буй, жендерийн тэгш бус байдал огт байхгүй зэргийг талархан хүлээж авч байлаа.

Мөн СЗХ-ны зүгээс “Дижитал платформ ба финтекийн эко систем дэх зохицуулалтын боломжууд” сэдэвт хэлэлцүүлгийг ахалсан нь Монгол Улсын хувьд шинэ хуудсыг нээсэн юм. Эцэст нь Дэлхийн санхүүгийн бодлогын чуулган амжилттай, мөнхүү ихээхэн ач холбогдолтой болж өндөрлөв. Энэ удаагийн чуулганд оролцсон Монгол Улсын СЗХ-ны оролцоо, түүний үр дүнг дээр дурдсан томоохон үйл ажиллагааны зэрэгцээ ажлын хэсгүүдийн хуралдаанууд, төр-хувийн хэвшлийн дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт, бүсийн санаачилгын зөвлөлийн хуралдаан гэх мэт олон үйл явдал, тэдгээрийн үр дүнгээр хэмжих учиртай.

**“Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн даатгал” олон улсын зөвлөлдөх VII уулзалтыг амжилттай зохион байгууллаа. /2019.9.17-18/**

Санхүүгийн зохицуулах хороо, ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) болон “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” хөтөлбөр (MEFIN, The Mutual Exchange Forum on Inclusive Insurance)-тэй хамтран Төр, хувийн хэвшлийн олон улсын зөвлөлдөх ээлжит VII уулзалтыг Улаанбаатар хотноо 2019 оны есдүгээр сарын 17-оос 18-ны өдрүүдэд зохион байгууллаа.



Зөвлөлдөх уулзалт нь уур амьсгал, гамшгийн эрсдэлийн даатгал (CRI)-ын эрхзүйн орчин ба зохицуулалт, түүний бизнес загвар, технологид суурилсан даатгалын салбар, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сэдвийн хүрээнд явагдсан ба уулзалтын үеэр “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” (MEFIN) хуралдаан болсон юм.

Түүнчлэн хурлын үеэр уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн даатгалын талаар нэгдмэл нэг ойлголттой байх тухай болон хууль эрхзүйн зохицуулалт, технологийн дэвшил, оролцогч бусад улс

орнуудын туршлага, уур амьсгалын даатгалын бүтээгдэхүүнийг бий болгох гол зорилготой бүлэг, түвшин зэрэг асуудлыг онцлон хэлэлцлээ.

**СЗХ-ны 25 жилийн ойд зориулсан “ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН” эрдэм шинжилгээний хурал амжилттай болж шилдгүүдийг шалгаруулав. /2019.11.15/**

Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жил, даатгалын салбарын 85 жилийн ойд зориулан судлаачид, оюутнуудын дунд шилдэг бүтээлийн уралдаан зарлаж, нийт 32 бүтээл ирснээс 12 бүтээлийг шалгаруулсан. Сонгогдсон 12 бүтээлээс оюутан, судлаачийн ангилал тус бүрээс шилдэг 3 бүтээлийг шалгаруулах эрдэм шинжилгээний хурал амжилттай боллоо.

Оролцогчдоос оюутны ангилалд тэргүүн байранд “Хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдалд “Miles-Ezzell болон Modigliani-Miller”-ийн засварлалтыг ашиглах нь” бүтээлээр МУИС-ийн оюутан Д.Ганбаяр, дэд байранд “Эх орны хишиг 1072 хувьцааг зохистой удирдах замаар хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж” бүтээлээр Мандах их сургуулийн оюутан Г.Бат-Эрдэнэ, Б.Нямтуяа нар, III байрт “Хувьцааны төвлөрөл болон ашгийн удирдлагын хоорондын хамаарлын шинжилгээ” бүтээлээр Мандах их сургуулийн оюутан Б.Алтанзул шалгарлаа.

Судлаачийн ангилалд тэргүүн байранд “Ноогдол ашиг ба нийлмэл Пуассоны процесс: Хувьцааны үнийн шинэ стохастик загвар” сэдвээр судалгаа хийсэн МУИС-ийн багш Г.Баттулга шалгарч, дэд байранд “Жолоочийн даатгалын итгэлцүүр гурвыг сайжруулах боломж” бүтээлээр МУИС-ийн багш Ч.Анхбаяр болон “Миг даатгал” ХХК-ийн Т.Шийрэв, III байрт “Давхар даатгалын дизайныг VAR-MIN, STE-MIN загваруудаар оновчлох” бүтээлээр Монголын Актурчдын мэргэжлийн институтын Д.Энхтайван болон Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн багш Д.Батсуурь нар тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналын эздээр тодров.




## ХЭРЭГЛЭГЧ

### ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан санал, дүгнэлт гаргаж хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2019 оны 3 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр нийт 259 өргөдөл иржээ.

Зураг 6: Өргөдлийн тоо (улирлаар)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоог 2018 оны мөн үетэй харьцуулахад 38.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж, зээлийн хоршооны салбаруудаас бусад зохицуулалтын салбаруудад хамаарах өргөдөл, гомдлын тоо өссөн бөгөөд ялангуяа даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо өмнөх онуудын улирлын үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн дээд хэмжээнд буюу 21.3 хувийн өсөлтөд хүрсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар тус Хорооны үндсэн чиг үүргийн нэг нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах бөгөөд 2015 оны 02 дугаар сард санхүүгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Хяналт шалгалт, зохицуулалтын газрыг байгууллагын бүтцэд шинээр бий болгож, тус газарт санхүүгийн хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хуулиар олгогдсон чиг үүрэг бүхий Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн нэгжийг байгуулав.

Тус нэгж нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан санал, дүгнэлт гаргаж хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг ба хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдлийн тоо, урьдчилан шийдвэрлэсэн хохирол барагдуулалтын дүнг дор харуулав. Үүнд:

Хүснэгт 1: Өргөдөл, хохирол барагдуулалтын тоо

№	Он	Өргөдлийн тоо	Хохирол барагдуулалт /сая төг/
1	2015	319	193.2
2	2016	442	182.4
3	2017	267	491.7
4	2018	340	622.3
5	2019-III	259	469.6
Нийт		1,321	1,959.2

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2015 оны 02 дугаар сараас даатгуулагчийн нөхөн төлбөрт нийт 168.5 сая төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргасан ба хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг зөвшөөрөлгүй арилжаалсан тохиолдлуудад 24.7 сая төгрөгийн хохирлыг барагдуулсан байна.

2016 онд даатгуулагчийн нөхөн төлбөрт нийт 165.9 сая төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргасан ба хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг зөвшөөрөлгүй арилжаалсан тохиолдлуудад 16.5 сая төгрөгийн хохирлыг барагдуулсан байна.

2017 онд даатгуулагч 30 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 490.6 сая төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргасан ба нийт 17 хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг зөвшөөрөлгүй арилжаалсан тохиолдлуудад 3 иргэний 1.1 сая төгрөгийн хохирлыг барагдуулж, “Улаанбаатар БҮК” ХК-ийн 150, “Ариг гал” ХК-ийн 168 ширхэг хувьцааг 1 иргэний дансанд тус тус нөхөн байршуулсан. Мөн 1 иргэний “Шивээ овоо” ХК-ийн 2,269, “АПУ” ХК-ийн 9, “Цагдуултай” ХК-ийн 4 ширхэг хувьцааг буцаан байршуулах, 1 иргэний “Махимпекс” ХК-ийн 2006 оноос хойших ногдол ашгийг нөхөн олгуулах, 11 иргэний хохирлыг барагдуулах шийдвэрийг гаргуулсан.

2018 онд даатгуулагч 29 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 622.3 сая төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргасан ба “Улаанбаатар хивс” ХК, “Тахь ко” ХК, “Материал импекс” ХК, “АПУ” ХК, “Дархан нэхий” ХК зэрэг компаниудын хувьцааг харилцагчийн дансанд буцаан байршуулах, “АПУ” ХК, “Дархан нэхий” ХК-ийн 2005 оноос хойших хугацааны ногдол ашгийг тооцон харилцагчдад олгуулах зэрэг 5 удаагийн хугацаатай үүрэг, даалгаврыг холбогдох үнэт цаасны компанид хүргүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн харилцагчийн дансанд “АПУ” ХК-ийн 40,000 ширхэг хувьцааг буцаан байршуулав.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар чиглэлийн хэмжээнд даатгуулагч 22 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 468.8 сая төгрөгийг олгуулах урьдчилсан шийдвэрийг гаргаад байна. Мөн нийт 15 иргэний өргөдлийн дагуу тэдгээрт учирсан хохирлыг барагдуулахаар 3 үнэт цаасны компанид үүрэг өгч, 5 иргэний үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь дансанд “Говь” ХК-ийн 5450, “Сор” ХК-ийн 28, “Махимпекс” ХК-ийн 12, “Дорнод” ХК-ийн 100, “АПУ” ХК-ийн 2900 ширхэг хувьцааг тус тус буцаан байршуулж, 2 иргэний хувьцаанд оногдох нийт 0.8 сая төгрөгийн хохирлыг бүрэн барагдуулаад байна. Мөн 13 иргэний хувьцааг зөвшөөрөлгүй зарсан үйлдлүүд нь гэмт хэргийн шинжтэй гэж үзээд “Аргай бэст ҮЦК” ХХК-тай холбоотой анхан шатны баримтуудыг бүрдүүлэн цагдаагийн байгууллагад шилжүүллээ.

Их20, OECD, Дэлхийн банкны судалгааны ажил, Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөмж зэрэгт тулгуурлан Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан ба энэ хүрээнд санхүүгийн боловсрол, хараат бус маргаан шийдвэрлэх механизмын тогтолцоо зэрэг зарим зохицуулалтыг уг хуулийн төсөлд тусгуулаад байна.

### САНХҮҮГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

**Давуу тал:** Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай

хуулиар Хороонд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүргийг олгосон байгаа тул G20-ийн зарчимд нийцсэн бол бусад орнуудын тухайд шинээр хуульчлах шаардлага үүсч байна.

Хороо нь Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016–2021”-ийг 2016 онд баталсан. Мөн эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах үүднээс “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг Сангийн яам, Монголбанк, Хороо хамтран боловсруулж, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор батлуулсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт, зохицуулалтын орчны үнэлгээг хийх, зохистой хяналт шалтгалтыг

зааглах, хамгааллын эрх зүйн тогтолцоо, мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн хүртээмжийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зорилтыг тусгасан зэрэг нь суурь нөхцлийг бүрдүүлээд байна.

**Сул тал:** Одоогийн байдлаар санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг нь Хяналт шалгалт, зохицуулалтын газрын бусад чиглэлүүдийн зохистой /prudential/ хяналт шалгалтын чиг үүрэгтэй давхцсан, хэрэглэгчийн эрхийг хамгаалах голлох үйл ажилбар өргөдөл, гомдол шийдвэрлэхэд хамаарч байгаа нь зохицуулалтыг шинэчлэн сайжруулах, зах зээлийн мэдээлэлд суурилсан судалгаа, шинжилгээ хийх болон мэдээллийн ил тод байдал, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, өргөдлийг хүлээн авах, барагдуулах зэргийг цахимжуулах бодлогын асуудлууд орхигдоход хүрч байна.




## ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

**Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар:** 2019 оны 3 дугаар улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,479.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 129.4 тэрбум төгрөг буюу 5.5 хувиар өссөн. Тайлант үед нийт 103.2 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 4.2 хувь болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.0 пунктээр нэмэгджээ.


Зураг 7: Зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадвар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**ЗЗҮ/ДНБ-ий харьцаа:** Тайлант улиралд ЗЗҮ-г 2018 оны жилийн эцсийн үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ий хэмжээтэй харьцуулахад 7.7 хувийг эзэлж байна. Энд өмнөх онуудын ДНБ-д эзлэх ЗЗҮ-ний үзүүлэлтийг тооцохдоо тухайн оны жилийн эцсийн ДНБ-ий дүнд хуваан тооцсон болно.

Зураг 8: Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээний хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


### ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

**Даатгалын гүнзгийрэлтийн түвшин:** Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй хэдий ч олон улстай харьцуулахад салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ доогуур байна. 2019 оны гуравдугаар улирлын байдлаар даатгалын гүнзгийрэлт 0.61 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.07 пунктээр нэмэгдэв.

Олон улсын хандлагаас харахад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт ердийн даатгалаас өндөр хувьтай байдаг бол манай орны хувьд нөхцөл байдал эсрэгээрээ байна. Европын болон Азийн зарим орнуудад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт

5 хувиас дээш, Өмнөд Африк болон Хятадад 10 хувиас дээш байхад манай орны хувьд сүүлийн жилүүдэд дунджаар 0.01 хувийг үзүүлжээ.


Зураг 9: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Нийт хөрөнгө:** Тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 14.02 хувиар, өмнөх улирлаас 5.3 хувиар өсөж 373.6 тэрбум төгрөгт хүрлээ. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад илүү өндөр буюу 15.9 хувиар өссөнөөр 289.5 тэрбум төгрөг болж, салбарын нийт хөрөнгийн 77.5 хувийг эзлэв. Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувиар нэмэгдэж 75 тэрбум төгрөг болсон нь салбарын нийт хөрөнгийн 20.1 хувийг, харин урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өсөн 9.1 тэрбум төгрөгт хүрч, нийт хөрөнгийн 2.4 хувийг эзэллээ.

Зураг 10: Даатгалын салбарын нийт хөрөнгө




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

**Банк бус санхүүгийн байгууллагуудын статистик үзүүлэлтүүд:** 2019 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн зах зээл дээр нийт 539 банк бус санхүүгийн байгууллага Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буурсан. Банк бус санхүүгийн байгууллагын харилцагчдын тоо 2.3 сая болж өмнөх оны мөн үеэс 1.5 дахин, нийт эзэлдэгчдийн тоо 383.7 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 1.8 дахин тус тус өслөө.

Зураг 11: Банк бус санхүүгийн байгууллагын тоо болон харилцагчдын тоо




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө:** 2019 оны 3 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 426.5 тэрбум төгрөгөөр буюу 35.5 хувиар өсжээ. Хөрөнгийн бүтцээс харвал энэхүү өсөлтийн 83.9 хувийг нийт зээлийн өсөлт дангаараа бүрдүүлж байна. Харин пассивын бүтцээс харвал өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 270.6 тэрбум төгрөгөөр буюу 29.0 хувиар өсөн 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь хөрөнгийн өсөлтийн 63.4 хувийг бүрдүүлж байна.

2019 оны 3 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт өөрийн хөрөнгө 1.2 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 29.0 хувиар нэмэгджээ.

Зураг 12: Нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО**

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт гишүүдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 13.3 хувиар буюу 8,240-өөр өсөж тайлант улиралд 70,121-т хүрсэн байна. Нийт гишүүдийн 63.6 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, үлдсэн 36.4 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.


Зураг 13: ХЗХ-дын тоо болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

**ХЗХ-дын хөрөнгө:** Тайлант улиралд хоршоод нийт 218.4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажилласан бөгөөд өмнөх оны мөн үеэс 13.6 хувийн өсөлтийг үзүүлэв.

Зураг 14: Нийт хөрөнгө, түүний өсөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын нийт хөрөнгийн 84.6 хувийг 1 тэрбумаас дээш хөрөнгөтэй 22 ХЗХ, 3.3 хувийг 500 саяас 1 тэрбум хөрөнгөтэй 11 ХЗХ эзэлж байгаа бол үлдсэн 12.1 хувийг 500 саяас доош хөрөнгөтэй 238 ХЗХ эзэлж байна.




## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ 2019 ОНД

2019 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 10 жилийн өмнө тохиосон санхүүгийн хямралаас хойших хамгийн удаан түвшиндээ хүрлээ. Худалдааны нөхцөлд үүдсэн саад бэрхшээл, тодорхой бус байдал нь бизнесийн үйл ажиллагаа, итгэлд сөргөөр нөлөөлсөн бол өндөр хөгжсөн улс орнууд болон Хятад улсын эдийн засаг мөчлөгийн болон бүтцийн шинж чанартай бууралтыг амслаа.

Түүнчлэн Бразил, Энэтхэг, Мексик, Орос улсуудад тохиосон эдийн засгийн саармагжилт дэлхийн эдийн засагт нөлөөлсөн бол Аргентин улсын санхүүгийн зах зээл дэх хатуу бодлого, Иран улсын геополитикийн зөрчил, болон Венесуэл, Ливи, Иэмэн улсуудад өрнөсөн нийгмийн зөрчил үймээн нь макро эдийн засгийн орчинд тохиосон томоохон үйл явдлууд байлаа.


Зураг 15: Дэлхийн эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн хувь нэмэр, хувиар, 2019



Энд: “Stressed” эдийн засагтай орнуудад Аргентин, Иран, Ливи, Судан, Турк, Венесуэл улсууд багтсан


Эдийн засгийн орчин тодорхой бус болохын хэрээр бизнесийн байгууллагуудын томоохон худалдан авалт буурч дэлхийн хэмжээнд машин, тоног төхөөрөмжийн борлуулалт буурлаа. Мөн өрхийн өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний эрэлт суларлаа. Уг үзүүлэлтэд хүлэмжийн хийн ялгаралт, байгаль орчны асуудлуудтай холбогдуулан улс орнуудын хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалт, стандартуудтай холбоотой автомобилын эрэлт буурсан нь голчлон нөлөөлсөн.

Зураг 16: Өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний зардал, өмнөх жилтэй харьцуулсан өөрчлөлт хувиар




Өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүний эрэлттэй холбоотойгоор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл мөн буурлаа.

Зураг 17: Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жилийн өөрчлөлт




Эдийн засгийн сулралтай холбоотойгоор 2019 онд Холбооны нөөцийн банк, Европын төв банк, болон хурдацтай хөгжиж буй хэд хэдэн эдийн засгуудын төв банкууд бодлогын хүүгээ буурууллаа.

Зураг 18: Бодлогын хүүгийн бууралт



Төв банкуудаас хэрэгжүүлсэн бодлого нь эдийн засгийн удаашралыг улам гүнзгийрэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бөгөөд хүүгийн түвшний бууралт санхүүгийн зах зээлийг дэмжсэн бодлого нь өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний худалдан авалтыг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүллээ. Мөн хөдөлмөрийн зах зээл дээрх чанга бодлого, цалингийн өсөлт нь хэрэглэгчдийн итгэлийг сэргээн өрхийн хэрэглээг дэмжлээ.

Зураг 19: Хэрэглэгчдийн итгэл болон ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан



2020 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

**2 ДУГААР САРЫН 18**

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн нэгдүгээр улирлын ээлжит хуралдаан

**5 ДУГААР САРЫН 12**

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хоёрдугаар улирлын ээлжит хуралдаан

**9 ДҮГЭЭР САРЫН 8**

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гувардугаар улирлын ээлжит хуралдаан

**12 ДУГААР САРЫН 8**

2020.12.08 Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн дөрөвдүгээр улирлын ээлжит хуралдаан



Монгол Улс, Улаанбаатар хот 15160  
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3  
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо